



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2013**

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	
Санхүүгийн зохицуулах хорооны даргын мэндчилгээ	3
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
Бүтэц зохион байгуулалт	5
ХОЁР. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР	6
ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ТАЛААР	8
ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА БОЛОН ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР	11
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНИЙ САНХҮҮГИЙН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	13
5.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ	13
5.1.1. Ерөнхий байдал	13
5.1.2. Хувьцаат компаниуд	15
5.1.3. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага.....	20
5.1.4. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц	20
5.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ	24
5.2.1. Даатгалын компаниуд	24
5.2.2. Даатгалын мэргэжлийн оролцогч байгууллага	34
5.3. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	35
5.3.1. Банк бус санхүүгийн байгууллага	35
5.3.2. Хадгаламж зээлийн хоршоо	39
ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ СУДАЛГАА, САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР	43
6.1. Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа	43
6.2. Компанийн засаглал	43
6.3. Зээлийн батлан даалтын сан	45
6.4. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт	46
6.5. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа	47
ДОЛОО. ХОРООНООС 2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГОЛ АЖЛУУД	47
ХАВСРАЛТУУД	
Хавсралт 1. Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх /2006-2013 он/	53
Хавсралт 2. Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах “Санамж бичиг”-тэй гадаад, дотоодын байгууллагуудын жагсаалт	54
Хавсралт 3. Санхүүгийн зохицуулах хорооноос 2013 онд баталж мөрдүүлсэн журам, заавар, нөхцөл шаардлага	55

ӨМНӨХ ҮГ



Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 оны үйл ажиллагааны тайлангаа Танд өргөн барьж байна.

Тайлант онд бид Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиуд шинээр батлагдсан, гадаад харилцаагаа өргөжүүлэн Хонгконгийн Үнэт цаас, Фьючерсын Хороотой хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулсан, үнэт цаасны зах зээлийг үл хөдлөх хөрөнгийн зах зээлтэй холбон зах зээлийн үнэлгээг 328 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн, санхүүгийн зах зээлд Хөдөө аж ахуйн биржийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр нэвтрүүлсэн зэрэг амжилтаар дүүрэн байлаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Үнэт цаасны төлбөр тооцооны системийн эрсдэлийн удирдлага, олон улсын санхүүгийн зах зээл дэх кастодианы үйл ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурал, Үнэт цаасны болон Даатгалын салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг тус тус зохион байгуулсан нь салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, системийн эрсдэлийн удирдлага, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох боломж бүрдсэн онцлог ажлууд болсон.

Мөн 2014 онд Олон улсын Үнэт цаасны Хороодын байгууллага/IOSCO/-ын жинхэнэ гишүүнээр элсэх, Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг/JICA/-ын техник хамтын ажиллагааны хүрээнд “Хөрөнгийн зах зээлийн хяналт зохицуулалт, удирдлагын чадварыг дээшлүүлэх” төслийг хэрэгжүүлэх, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг батлуулах, Даатгалын салбарын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, Хорооны эрхлэх асуудлын хүрээнд шинээр нэмэгдсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх үүднээс бүтэц, зохион байгуулалтаа оновчтой болгох зэрэг шинэ шинэ зорилтууд Хорооны өмнө тулгарч байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахаас гадна шинээр болон шинэчлэн батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хангах, хуулийг дагалдан гарах дүрэм, журам, заавар, стандартыг шинэчлэн буюу шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах, зохицуулалтын хүрээний байгууллагууд, иргэд хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, сурталчлах, газар дээрх болон зайнаас тавих хяналтыг сайжруулах зэрэг ажлуудыг хийнэ.

Хүндэтгэсэн,

Д.Баярсайхан

A handwritten signature in black ink, appearing to be 'D. Bayarsaikhan'.


Санхүүгийн зохицуулах хорооны дарга

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Бүтэц, зохион байгуулалт

Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 онд Тамгын газар, Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн санхүүгийн газар, Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар гэсэн 5 газар, Хорооны даргын дэргэдэх Дотоод хяналтын хэлтэс, Компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх албатайгаар үйл ажиллагаагаа явуулаа.



2013 онд Хороо 26 удаа хуралдаж 607 асуудал хэлэлцэн салбарын хэмжээнд дагаж мөрдүүлэх дүрэм, журам заавартай холбоотой 60, зохицуулалтын хүрээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой 272, тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үйл ажиллагааны хэлбэр нэмж олгохтой холбоотой 39, дүрмийн сан, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, эрх бүхий албан тушаалтан томилохтой холбоотой 120, оноосон нэр, хаяг өөрчлөхтэй холбоотой 16 шийдвэрүүдийг тус тус гаргасан ба 1670 иргэнд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрх, 146 салбар төлөөлөгчийн газар нээх асуудлыг шийдвэрлэсэн болно.

Мөн 2013 онд тус Хорооны эрхлэх асуудлын хүрээнд иргэд, хуулийн этгээдээс 323 өргөдөл гомдол ирснийг хянан шийдвэрлэж хуулийн хугацаанд нь хариу өглөө.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг 984 байгууллага хуулийн этгээд, 4477 иргэнд олгоод байна. /Хавсралт1/

Мөн 2013 оны байдлаар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гадаад дотоодын 22 байгууллагатай “Санамж бичиг” байгуулан хамтран ажиллаж байна. Үүнд: гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 6 байгууллага, Монгол улсын төрийн 6 байгууллага, зохицуулалтын салбарын 6 мэргэжлийн холбоод, 4 төрийн бус байгууллага, 1 хэвлэл мэдээллийн байгууллагатай тус тус санамж бичиг байгуулсан. /Хавсралт 2/

ХОЁР. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРХЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТАЛААР

Үнэт цаасны зах зээл: 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиуд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар үнэт цаасны бүртгэл, давхар бүртгэл, хувьцааг анх удаа, шинээр гаргах асуудал, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг арилжаалах, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчдын эрхзүйн статус харилцааг нарийвчлан зохицуулах, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах зэргээр олон чухал харилцаанууд зохицуулагдах боломжтой болсон.

Дээрх шинээр болон шинэчлэн батлагдсан хуулиудыг дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд 21 журам, дүрэм, заавар шинээр буюу шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт оруулан баталж мөрдүүлээ. Эдгээр журмуудыг мөрдүүлснээр хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, үнэт цаасны зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдлийг бууруулах, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

Мөн орон сууцны урт хугацаат зээлээр баталгаажсан үнэт цаасыг гаргах, энэ хэлбэрийн үнэт цаасыг баталгаажуулж буй үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл, шаардах эрх, үүргийн гүйцэтгэлийг хангуулах харилцааг зохицуулах зорилгоор “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны багцыг тусгай тэмдэглэл хийж, бүртгэх журам”-ыг баталж мөрдүүлээ.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан “МИК” ХХК-иас 8 хувийн хүүтэй орон сууцны урт хугацаат зээлээр баталгаажсан 328 тэрбум төгрөгийн үнэ бүхий үнэт цаас гаргах хүсэлтийг хянаж шийдвэрлэв. Ингэснээр үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг үнэт цаасны зах зээлтэй холбон улмаар үл хөдлөх хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх бодит боломж нээгдсэн.

2013 онд Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг орлогын 10 хувь байсныг хувьцааны арилжааны худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0,04 хувь болгож буурууллаа.

Үнэт цаасны зах зээлийн талаарх эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах ажлын хэсгүүдэд орж ажиллалаа. Үүнд:

1. Монгол Улсын эрдэс баялаг, газрын тосны салбарт хувьцаа гаргах эрхзүйн орчинг судалж, санал боловсруулах;
2. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх;
3. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;
4. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, зээлийн механизмыг шинэчлэх талаар санал боловсруулах;
5. “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх санамж бичгийг хэрэгжүүлэх;

6. Ашигт малтмалын стратегийн ордуудын тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй компаниудын хувьцааг “Эрдэнэс МГЛ” ХХК-д шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг зэрэг болно.

Даатгалын зах зээл: 2013 онд албан журмын даатгалын шинэ хэлбэрүүдийг бий болгох зорилгоор даатгалын зарим хууль тогтоомжийг шинээр боловсруулах, даатгалын багц дүрмэнд орсон журам, шаардлагуудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах, бусад байгууллагаас ирүүлсэн эрх зүйн актын төсөлд санал өгч тусгуулах, судалгаа хийх ажлуудыг хийлээ.

Нотариатчийн болон өмгөөлөгчийн хариуцлагын албан журмын даатгалын хэлбэрийг шинээр бий болгох зорилгоор шаардлагатай судалгааг хийсний үндсэн дээр хуулийн төсөл болон хуулийн үзэл баримтлалын төслийг эхний хувилбараар боловсруулав.

Жолоочийн даатгалын хуультай холбоотойгоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ болон давхар даатгалын чиглэлээр судалгаа хийж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулж Сангийн яаманд, даатгалын хураамжтай холбоотойгоор татварын хууль тогтоомжийг судалж даатгагчдын хүсэлтийн дагуу маргаантай зарим заалтыг тодруулж саналаа Татварын ерөнхий газарт тус тус хүргүүлээд байна.

Давхар даатгалын үндэсний компани байгуулах зорилтын хүрээнд малын даатгалын эрсдэлийг дотооддоо давхар даатгах эрхзүйн орчинг бий болгох чиглэлээр байгуулагдсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцож Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд саналаа тусгуулсан.

Даатгалын тухай хуулийн 27.1.1 дэх хэсэгт даатгагч “хувьцаа худалдаж авах, арилжих ...”-ыг хориглосон байсан заалтыг хүчингүй болгож өөрчлөх тухай хуулийн төсөл боловсруулж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахад Даатгалын тухай хуулийн дээрх өөрчлөлтийг хамт батлуулав.

Даатгалын багц дүрмийн хүрээнд даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг шинээр боловсруулах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгалын гэрээний нөхцөл, шаардлагыг сайжруулах, даатгалын нөхөн төлбөр олголтыг шуурхай болгоход чиглэсэн зохицуулалтыг нэмэгдүүлэх, даатгалын компанийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн эрхзүйн орчныг хөгжүүлэхэд түлхүү анхаарч 3 журам шинээр боловсруулж, одоо мөрдөгдөж байгаа 3 журам, зааврыг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд нийт 12 журам, шаардлагад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Даатгалын байгууллагуудаас дотоодод даатгуулж болох даатгалын зарим эрсдэлийг гадаадын даатгагчид шууд даатгуулснаас үүдэн их хэмжээний хөрөнгө даатгалын хураамжийн хэлбэрээр гадаад руу урсаж байгаад хяналт тогтоохыг хүссэн хүсэлтүүд Хороонд ирж байгаатай холбогдуулан шалтгаан нөхцөлийг судалж, олон улсын даатгалын зах зээлтэй холбогдсон нэмэлт судалгааг хийсний үндсэн дээр 8 журам, зааварт нэмэлт өөрчлөлтүүдийг орууллаа.

Бичил санхүү: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулсан. Уг хуулийн төслийн талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын хуралдаанд танилцуулга хийсэн ба уг хуралдаанаар Сангийн ямаар дамжуулан УИХ-д өргөн бариулах шийдвэр гарснаар хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлсэн.

Мөн гадаад валютын арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт, тэдгээрийн гаргасан зөрчилд хүлээлгэх хариуцлагын механизмыг ойлгомжтой, тодорхой болгох, төрийн хяналт, зохицуулалтад сөргөөр нөлөөлж байгаа нөлөөллийг бууруулах зорилгоор “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй бараа, үйлчилгээнд татвар ногдуулах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн ба тус хууль нь 2014 оны 1 дүгээр сард УИХ-аар хэлэлцэгдэж батлагдсан.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн журам, зааврыг шинээр буюу шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр батлуулж мөрдүүлээ.

Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар, дансны жагсаалт болон санхүүгийн тайлангийн маягтад өөрчлөлт оруулахаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад нийцүүлэн холбогдох журмын төслийг боловсруулан хянуулахаар Сангийн яаманд хүргүүлээд байна.

2013 оны 12 дугаар сараас эхлэн банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгодог боллоо. Энэ арга хэмжээ нь хувийн хэвшлийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаанд Төрөөс дэмжлэг үзүүлж буй чухал ач холбогдолтой шийдвэр болсон.

Түүнчлэн “Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан 2013 оны 3 дугаар улирлаас эхлэн хоршоодын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг шинэчилсэн маягтын дагуу “Fin-A” системээр хүлээж авч байна.

Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, санхүүгийн тайлангийн маягт шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг шинэчлэн баталж мөрдүүлээ. /Хавсралт 3/

ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ТАЛААР

Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид: 2013 онд нийт 8 мэргэжлийн оролцогч байгууллага болон мэргэжлийн оролцогчдын 5 салбарын үйл ажиллагааг шалгав. Мөн Монголбанкны Хяналт шалгалтын газартай хамтран “Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК-д шалгалт хийж гүйцэтгэлээ.

Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл аймгуудад үйл ажиллагаа явуулж буй нийт 21 хувьцаат компанид шалгалт хийлээ. Дээрх хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдалд 34 удаагийн захиргааны актаар нийт 5.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Монголбанкт хамтарч хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүйгээс Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх нь дуусгавар болсон нийт 130 Хувьцаат компанийн арилжааны банкууд дахь дансаар дамжуулан мөнгөн төлбөр тооцоо хийх эрхийг нь түр зогсоох ажлыг хэрэгжүүлэв. Мөн Төрийн өмчийн хороотой хамтарч хувьцаат компаниудын талаарх төрийн байгууллагуудад хөтлөгдөж буй бүртгэлийг тулгаж цэгцлэх, зарим төрийн өмчит компаниудын үнэт цаасыг бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангав.

Сүүлийн гурван жил дараалан Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаас гаргагчдын үүргээ биелүүлээгүй, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу шалгуур үзүүлэлт, нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй нэр бүхий 69 Хувьцаат компанийн үнэт цаасыг Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах зөвшөөрлийг олгосон.

Үнэт цаасны зах зээлд бүртгэлтэй 323 Хувьцаат компанийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн дүн мэдээ, гүйцэтгэсэн ажлын тайланд зайны хяналт хийлээ. 2013 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг нийт 68 мэргэжлийн байгууллага цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн ба 2012 оны санхүүгийн

тайланг аудитын байгууллагаар баталгаажуулах ажилд хяналт тавьж ажиллан, “Fin-A” системээр мэргэжлийн оролцогчдын 2013 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийг гаргасан.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хийх зайны хяналтыг чанаржуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон зөрчил, дутагдлыг арилгах талаар 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хариугаар 78 мэргэжлийн оролцогчдод хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг бүрэн хангуулан ажиллав. Мэргэжлийн оролцогчдын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн санг шинэчилсэн ба 2013 оны 9 сард цахим хуудсанд үе шаттайгаар байршуулах ажил хийгдэж дууссанаар уг сангийн мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглах боломж бүрдсэн.

Даатгалын байгууллага болон даатгалын мэргэжлийн оролцогчид: 2013 онд нийт 10 даатгалын компани, 3 даатгалын хохирол үнэлэгч компани, 8 даатгалын зуучлагч компани, даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй аудитын 32 компанийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийсэн. Эдгээр шалгалтын явцад нийт 72 зөрчил, дутагдалд 39 удаагийн арга хэмжээгээр 52,9 сая төгрөгийн торгууль ногдуулж бүрэн төлүүлсэн.

Мөн 21 аймагт даатгалын төлөөлөгчийн сургалтыг зохион байгуулж хяналт тавихдаа даатгалын компаниудын орон нутаг дахь 182 салбарын ажил байдалтай газар дээр нь үзлэг хийж танилцсан. Энэ ажлын хүрээнд Хорооноос баталж гаргасан даатгалын салбарт тавигдах шаардлагыг бүрэн ханган ажиллаж чадаагүй даатгалын 5 салбарын зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Мөн даатгалын компанийн цэвэр хураамжийн хувь хэмжээ болон актуарын тайланг хянаж, нэгдсэн дүгнэлтийг гаргасан ба Компаниуд цэвэр хураамжийн хувийг доогуур тооцож ирүүлэх зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан.

Хорооноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 17 даатгалын компаниуд өөрсдийн санхүүгийн тайлангаа өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд мэдээлсэн байдалд хяналт тавьж ажилласан. Аудитын тайлан хожимдсон гэсэн шалтгаанаар 3 даатгалын компани олон нийтэд мэдээлэх хугацааг хожимдуулсан.

Даатгалын байгууллагуудын 2012 оны жилийн эцэс болон 2013 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлангуудад зайны хяналт явуулж, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг компани тус бүрт хүргүүлсэн. Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас хоцроосон компаниудад хариуцлага тооцож, 100 мянган төгрөгийн торгууль оногдуулж барагдуулсан. Нийт 83 удаа зайны хяналт хийж, тайлангийн хариуг компаниудад хүргүүлсэн.

Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоод: Тайлант онд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нэр бүхий 30 банк бус санхүүгийн байгууллага, 37 хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг тус тус хийлээ.

Цаг үеийн шаардлагаар болон Валютын зохицуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнөөс гадуур 4, 9,10 дугаар сард Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутагт дэвсгэрт гадаад валютын арилжаа эрхэлдэг давхардсан тоогоор 125 иргэн, хуулийн этгээдэд үзлэг шалгалтыг хийж үүрэг даалгавар өгч хариуцлага тооцон ажиллалаа.

Мөн 2013 оны 11, 12 дугаар саруудад гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй Банк бус санхүүгийн байгууллагуудын валют худалдсан буюу худалдан авсан анхан шатны баримтуудыг цахим тайлантай тулгалт хийсэн ба ажлын аюулгүй байдлыг хангаагүй, хяналтын камерын бичлэг хийдэггүй, кассын машингүй, валютыг худалдан авах, худалдах бүрт 2 хувь баримт үйлдээгүй гэх мэт зөрчилтэй 20 банк бус санхүүгийн байгууллагуудад дахин үзлэг, шалгалтыг хийж, зөрчил дутагдал давтагдсан буюу зөрчлөө арилгаагүй 13 банк бус санхүүгийн байгууллагуудад тус бүр 3,8 сая төгрөгийн захиргааны торгууль ногдууллаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын хэрэгжилтийг

хангуулж, хяналт тавих үүрэг бүхий 228 ажилтныг банк бус санхүүгийн байгууллагуудад томилуулсан.

2013 оны эхэнд 145 хоршооны 68 нь хяналт тавих ажилтныг томилон ажиллуулж байсан ба удаа дараа үүрэг даалгавар өгч ажилласны дүнд 50 хоршоо ажилтнаа нэмж томилон, 2013 оны эцэст үйл ажиллагаа явуулж буй 141 хоршооны 118 нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээд байна.

Мөн гадаад валютын арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаатай хамтран хяналт шалгалт явуулах зорилгоор Чингэлтэй дүүргийн Засаг даргад санал тавьж тус дүүргийн Татварын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, 1, 2, 3 дугаар хороодтой хамтарсан газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, нэгдсэн тайланг гаргаж Дүүргийн удирдлагад танилцууллаа. Хамтарсан шалгалтаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Валютын зохицуулалтын тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Татварын тухай болон бусад хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хугацаатай өгсөн үүрэг даалгавар, захиргааны хариуцлага ногдуулалтын биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллан 16 банк бус санхүүгийн байгууллага, 15 хадгаламж, зээлийн хоршоонд Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн 28 байгууллагад 72.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж, зээлийн хоршоодын 2012 оны болон 2013 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг “Fin-A” системээр хугацаанд нь чанартай хянаж нэгтгэн салбарын нэгдсэн танилцуулгыг гаргаад байна.

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 209 банк бус санхүүгийн байгууллага, 142 хадгаламж, зээлийн хоршоо, 2013 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланг давхардсан тоогоор нийт 703 банк бус санхүүгийн байгууллага, 416 хоршоодоос хүлээн авч хяналаа. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудын гадаад валютын арилжааны сар тутмын мэдээг 2012 оны жилийн эцэс, 2013 оны 1, 2, 3 дугаар улирлаар нэгтгэн гаргаж Монголбанкинд хүргүүлэв.

Орон нутагт бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангах, хоршооны гишүүд, ажилтнуудыг сургалтад хамруулах, нягтлан бодох бүртгэл, мэдээллийн программ хангамжийг нэвтрүүлэх, иргэдэд сургалт сурталчилгаа явуулах чиглэлээр 2006 оноос эхлэн Хас банктай “Санамж бичиг” байгуулан ажилласан.

“Санамж бичиг”-ийн хүрээнд Франчайзын гэрээ байгуулсан хоршоодын санхүүгийн тайланг нэгтгэн дүгнэж алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын судалгааг гаргалаа.

Аудитын байгууллагаар санхүүгийн тайлангаа баталгаажуулсан байдалд хяналт тавихад банк бус санхүүгийн байгууллагууд 100 хувь, хадгаламж, зээлийн хоршоод 97.9 хувь баталгаажуулж, 99.5 хувь буюу 211 банк бус санхүүгийн байгууллага аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлсэн байна.

Тусгай зөвшөөрөл авсан, оноосон нэр, байршил өөрчилсөн, нэмэлт зөвшөөрөл авсан 62 банк бус санхүүгийн байгууллага, хоршооны нийт 37,9 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 212 банк бус санхүүгийн байгууллага, 149 хадгаламж, зээлийн хоршооны 221,9 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус тус төвлөрүүлээ.

Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд банк бус санхүүгийн 212 байгууллагын 97 нь Зээлийн мэдээллийн сантай холбогдон зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглаж байна.

ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА БОЛОН ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Хорооны нийгмийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг сайжруулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд зориулан Мэргэжлийн холбоод, гадаад дотоодын төслийн багтай хамтран буюу дангаар давхардсан тоогоор нийт 94 удаагийн сургалт, 25 удаагийн семинар, 2 удаагийн уулзалт хэлэлцүүлэг зэрэг 120 гаруй зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Үнэт цаасны төлбөр тооцооны системийн эрсдлийн удирдлага, олон улсын санхүүгийн зах зээл дэх кастодианы үйл ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурал, Үнэт цаасны зах зээл, Кастодиан үйлчилгээ, хөрөнгө оруулалтын сан, даатгалын зах зээл, бичил санхүүгийн салбар, компанийн засаглал, стратегийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр гадаадын 9 экспертийг давхардсан тоогоор 12 удаа урьж ажиллуулав.

Мөн “Компанийн тухай хуулийн шинэ зохицуулалт” сэдвээр хувьцаат компани, аудитын компаниудын удирдлагууд, мэргэшсэн үнэлгээчид, үнэт цаасны зах зээлд оролцогчид, олон нийтэд зориулан нийт 6 удаа сургалт зохион байгууллаа. Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймагт ажиллан орон нутгийн захиргаа, хувьцаат компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч, зах зээлийн эдийн засгийн болон эрх зүйн харилцааны зохицуулалтын талаар танилцуулга хийсэн.

Түүнчлэн олон нийтийн телевизээр нийт 7 удаагийн сэдэвчилсэн нэвтрүүлэгт оролцож, үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх ярилцлага өгсөн.

Хөрөнгийн зах зээл болон компанийн засаглалд нийтлэг хэрэглэгддэг үг хэллэг, нэр томъёог багтаасан “Хөрөнгийн зах зээлийн нэр томъёоны тайлбар толь”-ийг салбарын мэргэжлийн оролцогч байгууллагууд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулж олон нийтэд түгээлээ. Энэ нь үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчид болон зохицуулагч байгууллагуудын ойлголтуудыг жигдлэх, нэг мөр ойлгож хэрэглэхэд ач холбогдолтой боллоо.

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 2013 оны 3, 11 дүгээр саруудад үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтний эрх олгох сургалт явуулж шалгалт авсан ба 2013 онд нийт 150 иргэн үнэт цаасны зах зээл дээр брокер дилерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авч, 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрхтэй иргэн 1178 байна.

Мөн үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын удирдах ажилтны 2 дугаар зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Төрийн өмчийн хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК, “ҮЦТТХТ” ХХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн нийт 55 байгууллагын 80 гаруй удирдах ажилтнууд оролцлоо. Уг зөвлөгөөний үеэр үнэт цаасны зах зээлийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн орчин, дэд бүтцийн шинэчлэл, тулгамдаж буй зарим асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ, төлбөр тооцооны тогтолцооны хэтийн төлөвийг тодорхойлох зөвлөмжийг гаргаад байна.

Кастодианы үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн журмын төслийг боловсруулах ажлын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэгт холбогдох төрийн байгууллагуудаас гадна арилжааны банкууд, брокер дилер, андеррайтерийн компани, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагч, хуулийн болон аудитын компанийн төлөөлөл оролцож шинээр үүсч буй үйлчилгээ, зах зээлийн дэд бүтцийн орчныг зохицуулалтын талаар холбогдох санал гаргасныг төсөлд тусгалаа.

2013 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн

найруулга батлагдсантай холбогдуулан Монголбанктай хамтран мэргэжлийн байгууллагуудыг хамруулсан семинар зохион байгуулав.

Мөн Компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимтай хамтран “Компанийн тухай хуулийн хэрэгжилт, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ ба компанийн засаглалын кодексын өөрчлөлт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт хувьцаат компаниудын удирдлага, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон Хороонд бүртгэлтэй хуулийн компаниудын төлөөллийг хамруулав.

Сангийн яамтай хамтран Даатгалын салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг зохион байгуулж, даатгалын салбарыг хөгжүүлэх бодлогын асуудлаар санал солилцсон бөгөөд одоо мөрдөгдөж байгаа даатгалын зохицуулалтын хууль тогтоомжууд болон хяналт шалгалтын журам, зааврын талаар илтгэл тавьж чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Даатгалын мэргэжлийн оролцогчдод зориулсан сургалтуудыг 64 удаа, Даатгалын компаниудад шинээр төлөөлөгчөөр ажиллах иргэдэд зориулсан даатгалын төлөөлөгчийн сургалтыг 23 удаа, Даатгалын хохирол үнэлэгч, даатгалын зуучлагчийн сургалтуудыг 1 удаа тус тус зохион байгууллаа.

2013 онд 21 аймагт даатгалын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор сургалт сурталчилгааны ажлыг даатгалын төлөөлөгчийн сургалттай хослуулан хийж, орон нутгийн хэвлэл мэдээллийн туслалцаатайгаар иргэд, даатгуулагчидтай үулзалт, ярилцлагуудыг зохион байгуулсан.

Зохицуулалтын байгууллагууд, тэдгээрийн ажилтнуудад зориулсан 21 удаагийн сургалтад давхардсан тоогоор 486 банк бус санхүүгийн байгууллагуудын 524 ажилтан, албан хаагч хамрагдсан.

АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын удирдлага, эрсдэлүүд, хяналт, шалгалт” сэдэвт сургалтад нийт 6 банк бус санхүүгийн байгууллагын 9 төлөөллийг оролцуулав.

Хадгаламж, зээлийн хоршооны ажилтнуудад зориулан зохион байгуулсан “Нягтлан бодох бүртгэл”-ийн сургалтад 22 хоршооны 27 ажилтан, Хадгаламж, зээлийн хоршоодын засаглалыг сайжруулах семинарт Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж буй 31 хоршооны төлөөлөгч тус тус хамрагдлаа.

Хадгаламж, зээлийн хоршооны ажилтнуудад зориулсан зайны болон танхимын сургалтын модулийг боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэн 16 хоршооны 160 сонгуульд ажилтнуудад сургалт явуулаад байна. Түүнчлэн олон улсын зөвлөхийн өгсөн зөвлөмжөөр 83 хоршооны 166 ажилтныг оролцуулсан сургалт хэлэлцүүлгийг хийсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын хоршооны хөгжлийн явц болон цаашдын хөгжил дэвшил, төрөөс баримтлах бодлогод хэрхэн нийцэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор төслийн үндэсний болон олон улсын зөвлөхийн хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулж Улаанбаатар хот, Төв, Орхон, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Архангай, Хөвсгөл аймгуудын нийт 79 хоршоодын гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарын нийт 128 ажилтан оролцлоо.

“Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага-2013” семинарыг зохион байгуулж гадаад, дотоодын эрдэмтэн судлаач, салбарын мэргэжлийн байгууллагууд, төрийн байгууллагуудын төлөөлөл 22 хүний илтгэлийг нь хэлэлцүүлээ. Семинарт нийт 130 хүн оролцсон.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНИЙ САНХҮҮГИЙН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5. 1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

5.1.1. Ерөнхий байдал

Манай орны хувьд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшин доогуур, санхүүгийн зуучлалын бодит шинжээ олоогүй өнөөгийн нөхцөлд үнэт цаасны зах зээлийн хөгжил нь эдийн засгийн өсөлтөөс шууд хамаарах хандлагатай байна. Үнэт цаасны зах зээлийн хөгжил нь эдийн засгийн өсөлтөөс шууд хамааралтайгаар хөгжиж байгаа нь өөрөө мөчлөг дагасан шинжтэй ба эдийн засгийн өсөлттэй жилүүдэд хэт халах буюу үнэт цаасны үнэ, ханш дагаж нэмэгддэг, эдийн засгийн уналттай жилүүдэд зах зээл дээрх хувьцааны үнэ ханш эрс буурдаг хандлага зах зээлийн үзүүлэлтүүдээс харагдаж байна.

Зах зээлийн үнэлгээ: Үнэт цаасны зах зээлийн нийт эдийн засгийн бүтцэд эзлэх хувийг зах зээлийн үнэлгээгээр илэрхийлэх ба уг үнэлгээг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй компанийн гаргасан үнэт цаасны тоог тухайн өдрийн хаалтын ханшаар үржүүлэн тооцоход 2013 оны зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 129.4 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар буурч, 1,670.5 тэрбум төгрөгт хүрээд байна. Үнэлгээ өндөр 30 компани нийт үнэт цаасны зах зээлийн үнэлгээний 87.6 хувийг эзэлж байна.

График-1




Зах зээлийн үнэлгээ 2005 оноос 2010 он хүртлэх хугацаанд тогтмол өсөх хандлага ажиглагдсан ба 2011 онд өсөлтийн хүрд огцом нэмэгдсэн хэдий ч эргээд 2012-2013 онуудад буурсан байна.

Зах зээлийн үнэлгээ өсөж буурах нь эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчдын зах зээлд хандах хандлага, гадаад худалдааны тэнцэл зэрэг макро эдийн засгийн хувьсагчдаас хамааралтай байгаа бол микро түвшинд нийт бүртгэлтэй компанийн хувьцааны тоо, хувьцааны үнийн дүнгээс шууд хамааралтай.

Үнэт цаасны зах зээлийн капиталын багтаамжийг илэрхийлэгч үндсэн суурь үзүүлэлт болох Зах зээлийн үнэлгээг 2013 оны дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргаар тооцсон урьдчилсан гүйцэтгэлд харьцуулахад 9.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График-2



Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь өмнөх оны мөн үеийнхээс буурсан, эдийн засгийн өсөлтөд үнэт цаасны зах зээлийн зуучлалын үзүүлэх нөлөө сул байгаа нь дараахь хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзэхээр байна.

1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд нь эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай явагддаг, улирлын болон мөчлөг дагасан шинжтэй;
2. Зах зээл дэх шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлт хангалтгүй;
3. Бүртгэлтэй компаниудын хувьцааны төвлөрлийн хэмжээ өндөр;
4. Мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүү, хүний нөөцийн чадамж сул, төлбөр тооцооны шинэ горимд шилжсэнтэй холбогдуулан арилжааны дүн буурсан зэрэг болно.

Зах зээлийн хөрвөх чадвар: Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг илэрхийлэгч хөрвөх чадварын үзүүлэлтийг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компанийн хувьцааны тоо ширхэгт тухайн оны арилжигдсан үнэт цаасны тоо ширхэгийг харьцуулан тооцож байв. Энэ аргаар тооцох нь олон улсад нийтлэг хэрэглэгддэг стандарт тооцоололтод тохирохгүй байсан тул 2013 оноос эхлэн Олон улсын валютын сан болон Дэлхийн банкны тооцоололтод ашиглагдаж буй тухайн онуудад арилжигдсан хувьцааны үнийн дүнг тухайн оны зах зээлийн үнэлгээнд харьцуулах аргаар тооцож эхлээд байна.

Хүснэгт 1

Он	Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөгөөр/	Хувьцааны арилжааны үнийн дүн /тэрбум төгрөгөөр/	Хөрвөх чадвар
2006	131	12,6	9,6
2007	717,6	62,1	8,7
2008	515,8	60,3	11,7
2009	620,7	23,2	3,7
2010	1373,9	62,8	4,6
2011	2168,5	109,1	5,0
2012	1799,9	144,7	8,0
2013	1670,5	97,6	5,9



Тайлант хугацааны зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлт 5.9 хувь байгаа нь хөрвөх чадвар хангалтгүй, зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нь эрэлт, нийлүүлэлтийн огтлолцлоор тогтохгүй байгааг харуулж байна.

5.1.2. Хувьцаат компаниуд

График-4



Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд найдваргүй үнэт цаас худалдан авч алдагдал хүлээхээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах, Хөрөнгийн биржийн бүртгэлийг олон улсын нийтлэг жишиг хүргэх бодлого, зорилтын хүрээнд 2013 онд Хорооны зүгээс үнэт цаасны бүртгэлийн шаардлагыг хангуулахаар судалгаа хийж хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй 69 компанийн үнэт цаасыг Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах зөвшөөрлийг олгосон.

Цаашид мэргэжлийн зуучлагчид хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, 75 хувиас дээш төвлөрөлтэй хувьцаат компанийн удирдлагуудад нэмэлт хувьцаа гаргах, хувьцаагаа задлах талаар чиглэл өгч тодорхой хугацаанд биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд бүртгэлээс хасах хүртэлх арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлүүд болох хадгаламжийн бичиг, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, кастодианы үйлчилгээ, институционал хөрөнгө оруулалтын дэд бүтэц төлөвшснөөр ойрын хоёр жилийн хугацаанд зах зээлийн хөрвөх чадвар огцом нэмэгдэх боломж байна.

Зах зээлийн индекс: Үнэт цаасны зах зээлийн үр ашигт байдлын гол үзүүлэлт бол зах зээлийн индекс. Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 18301.93, доод үзүүлэлт 13188.46, дундаж үзүүлэлт 15094.94 нэгж байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1412.70 нэгжээр буюу 7.97 хувиар буурч, 16301.81 нэгж болсон байна.

График-5



2013 онд индексийн үзүүлэлт буурахад макро түвшинд гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд оролцох оролцоо багассан бол, микро түвшинд ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлж буй нэр бүхий компаниудын хувьцааны ханш унасантай холбоотой. Үүнд: “Би Ди Сек” ХК 33.77 хувь, “Таван толгой” ХК 31.19 хувь, “Хөх ган” ХК 23.53 хувь, “Шивээ овоо” ХК 23 хувь, “Монголын цахилгаан холбоо” ХК 18.97 хувь, “Шарын гол” ХК 12.45 хувь, “Багануур” ХК 11.93 хувь, “Ремикон” ХК-ийн хувьцааны ханш 11.11 хувиар тус тус буурав.

2013 оны байдлаар Хороонд 323 компани бүртгэлтэйгээс, төрийн өмчийн оролцоотой 30, төрийн өмчит 23, хувийн өмчит 270 компани байна. Нийт бүртгэлтэй компанийн тоо тасралтгүй буурах хандлагатай бол Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас нь арилжигдахгүй байгаа компанийн тоо тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна.



Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаат компаниудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт сайжран, Хорооны зүгээс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэх хүчтэй эрх зүйн орчин бүрдээд байна.

График-7



Ногдол ашиг тараалт: 2013 онд Хорооноос дөрвөн үе шаттайгаар Компанийн тухай хуулийн дагуу хувьцаат компаниуд, тэдгээрийн удирдлагад тавигдаж буй шаардлага, хуулиар хүлээсэн үүргийн талаар анхааруулга мэдээллийг хүргүүлсэн ба үүний үр дүнд хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2

№	Ногдол ашиг тараасан	Санхүүгийн тайлан ирүүлсэн	Дүрмээ шинэчлэн баталсан	ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгосон
	30 ХК	204 ХК	161 ХК	122 ХК

2013 оны ногдол ашиг тараалтын үзүүлэлтээс үзэхэд ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн компанийн тоо өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдсэн хэдий ч тараасан мөнгөн дүнгийн хэмжээ даруй 7 дахин буурсан үзүүлэлттэй байв.

Ногдол ашиг тараалтын мөнгөн дүн буурахад голчлон “Таван толгой” ХК-ийн ногдол ашиг тараалтын хэмжээ ихээхэн буурсан нь нөлөөлжээ.

Мөн макро түвшинд авч үзвэл нийт бүртгэлтэй дийлэнх хувьцаат компанийн хяналтын багц нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн, компанийн засаглал сул, санхүүгийн зуучлалын шинэлэг хэрэгслүүдийн нэг болох кастодиан банкны үйлчилгээ хараахан нэвтэрч эхлээгүй байгаа нь нөлөөлж байна.

Хүснэгт 3

д/д	Компанийн нэр	Тоон код	Үсгэн код	Салбар	Байршил	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Нийт хувьцааны тоо ширхэг	Ногдол ашгийн нийт дүн /төг/	Тараах хэлбэр
1	Говь	354	GOV	В	УБ	125	7 801 125	975 140 625	ХК, ҮЦТТХТ
2	Гермес центр	528	HRM	Е	УБ	5,09	78 543 001	399 783 875	ҮЦТТХТ
3	Шарын гол	309	SHG	А	ДА	50	10 231 389	511 569 450	ҮЦТТХТ
4	АПУ	90	APU	В	УБ	70	74 287 700	5 200 139 000	ҮЦТТХТ
5	Бидисек	522	BDS	Е	УБ	60	11 000 000	660 000 000	ҮЦТТХТ
6	Тахь-ко	44	ТАН	В	УБ	56	1 189 983	66 639 048	ҮЦТТХТ
7	Баянтээг	445	BTG	А	ӨХ	100	252 608	25 260 800	ҮЦТТХТ
8	Улаанбаатар БҮК	195	BUK	Д	УБ	137	1 128 275	154 573 675	ҮЦТТХТ
9	Тулга	5	TLG	Е	УБ	60	131 620	7 897 200	ҮЦТТХТ
10	Тээвэр дархан	217	ТЕЕ	Д	ДА	400	163 349	65 339 600	ҮЦТТХТ
11	Монгол алт	68	ERC	А	ДА	150	265 852	39 877 800	ҮЦТТХТ
12	Ремикон	530	RMC	В	УБ	1,27	78 679 464	100 000 000	ҮЦТТХТ
13	Махимпекс	208	MMX	В	УБ	80	3 800 721	304 057 680	ХК
14	Баянгол ЗБ	13	BNG	Е	УБ	350	423 065	148 072 750	ҮЦТТХТ, ХК
15	Женко тур бюро	521	JTB	Е	УБ	1,6	100 000 000	160 000 000	ҮЦТТХТ, ХК
16	Оллоо	527	OLL	Е	УБ	6	9 700 497	58 202 982	ҮЦТТХТ
17	Атар-Өргөө	17	ATR	В	УБ	500	174 136	87 068 000	ҮЦТТХТ
18	Газар сүлжмэл	34	SUL	В	УБ	4948,2	65 362	323 424 248	ҮЦТТХТ
19	Дорнод худалдаа	311	DES	Е	ДО	500	73 969	36 984 500	ҮЦТТХТ
20	Барилга корпораци	476	BRC	Д	УБ	5000	40 662	203 310 000	ХК
21	Гутал	88	GTL	В	УБ	420	1 618 684	679 847 280	ХК
22	Могойн гол	444	BDL	А	ХӨ	5	829 622	4 148 110	ҮЦТТХТ
23	Ээрмэл	191	EER	В	УБ	52,87	3 479 320	183 951 648	ҮЦТТХТ
24	Материал импекс	379	MIE	Е	УБ	100	1 368 206	136 820 600	ҮЦТТХТ
25	Ган хэрлэн	353	HZB	Е	ДО	300	99 899	29 969 700	ҮЦТТХТ
26	Улаанбаатар ЗБ	3	ULN	Е	УБ	300	335 297	100 589 100	ҮЦТТХТ
27	Техник импорт	441	TEX	Е	УБ	300	1 446 755	434 026 500	ҮЦТТХТ
28	Талх чихэр	22	TCK	В	УБ	100	1 023 703	102 370 300	ХК
29	Адуун чулуун	461	ADL	А	ДО	70	3 151 304	220 591 280	ҮЦТТХТ
30	Эрдэнэт суврага	377	SVR	Д	БУ	5	156 054	780 270	ҮЦТТХТ
НИЙТ							391 461 622	11 420 436 022	-

График 8



Бондын арилжаа: Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан компанийн бондын арилжаа явагдаагүй байна. Компанийн бондын арилжаа идэвхгүй явагдаж байгаа нь компаниуд хөрөнгө оруулалтын эх үүсвэрээ банкны богино хугацаат зээлээр санхүүжүүлэх бололцоо өндөр байгаа, үнэт цаасны зах зээлийн хэмжээ, хөрвөх чадварын хувь доогуур байгаа нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулах боломжийг бууруулж байна.


Цаашид компаниудыг үнэт цаасны зах зээлд бонд гаргах замаар банкны богино хугацаат зээлийн хүү өндөр эх үүсвэрээр санхүүжүүлэх нөхцөлийг бууруулах, компанийн бондод хөрөнгө оруулах сонирхол бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, иргэд аж ахуйн нэгжид бондын санхүүжилтийн талаарх мэдлэг мэдээллийг олгох нь зүйтэй байна.

График-9




2013 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан 1.01 тэрбум төгрөгийн Засгийн Газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаад байна. Засгийн Газрын бондын арилжааны дүн бага байгаа нь Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайдын 2012 оны 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн Газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам”-ыг баталж, 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн Засгийн Газрын үнэт цаасыг Монголбанкны платформуур дамжуулан зөвхөн арилжааны банкуудаар арилжаалагдаж эхэлсэнтэй холбоотой юм.

Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа (тэрбум төгрөг)



Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа (тэрбум төгрөг)



Иймд Засгийн Газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан арилжаалж, олон нийтэд өгөөж өндөртэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн Хорооны зүгээс цаашид Засгийн Газрын үнэт цаасны хоёрдогч арилжаанд хяналт, зохицуулалтыг тогтмолжуулах нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд түлхэц өгөх нь тодорхой юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: 2010 онд Улсын Их Хурлаас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль баталснаар ирээдүйд мөнгөн урсгал бий болгох боломжтой актив, тухайлбал үл хөдлөх хөрөнгийн зээл /моргейж/-ээр баталгаажсан үнэт цаас хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах эрх зүйн боломжтой болсон ч хөрөнгийн зах зээл дээр ийм төрлийн бүтээгдэхүүн гараагүй байсан юм. Харин өнгөрсөн 2013 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн урт хугацаат орон сууцны зээлийг үнэт цаасжуулалт хийж үл хөдлөх хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбох ажиллагаа явагдсан.

Тодруулбал, “МИК” ХХК-иас гаргасан нийт 328 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу бүртгэж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэж тооцоод байна. Гэхдээ тус үнэт цаас нь хөрөнгийн бирж дээр арилжаалагдаагүй ба хаалттай хүрээнд арилжааны банкуудад арилжаалагдсан ч төлбөр тооцоо нь “ҮЦТТХТ” ХХК-иар дамжин хийгдэж байгаа болно.

Дээрх баталгаат үнэт цаас гаргах ажиллагаа нь бусад олон төрлийн үйл ажиллагааг бий болгох бөгөөд тухайлбал, тусгай зориулалтын компани, үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах зэрэг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоод байгаа бөгөөд цаашид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгүүлэх, Хөрөнгийн биржээр дамжин олон нийтэд арилжаалагдах ажиллагаа эрчимтэй явагдах төлөвтэй байна.

Энэхүү төрлийн үнэт цаас нь хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдсанаар Хөрөнгийн бирж дээр арилжаалагдах бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэх, хөрөнгө оруулах шинэ санхүүгийн хэрэгсэл бий болох зэрэг ач холбогдолтой бол энэ хэмжээгээр хөрөнгийн зах зээлийн хэмжээ, үнэлгээ нэмэгдэх юм.

Мөн 2013 онд төрийн өмчит “МИАТ” ХК-ийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр гаргаж буй нийт 20 сая америк долларын үнийн дүн бүхий бонд /өрийн хэрэгсэл/-ыг бүртгэсэн ба тус компани дээрх бондыг арилжаалахаар бэлтгэж байна. Монгол улсад бүртгэлтэй компанийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр гаргах үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэх нь тухайн орны зохицуулах, хяналт тавих байгууллага болон хөрөнгийн биржид уг үнэт цаасыг бүртгүүлэхэд ихээхэн дөхөм болдог. Тийм учраас энэ нь үнэт цаас гаргагчийн хувьд чухал хөшүүрэг тул Хороо энэ хэлбэрийн үнэт цаасыг бүртгэхдээ аль болох түргэн шуурхай хандах зарчмыг баримталдаг.

5.1.3. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага

2013 оны эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 87 компани, Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээ эрхлэх 11 арилжааны банк, ассет менежментийн 1 компани, давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 17 компани бүртгэлтэй байна.



Брокерын үйлчилгээг орон нутгийн иргэдэд ойртуулах ажлын хүрээнд Завхан, Хөвсгөл аймагт “Гүүдсек” ХХК болон Дархан, Эрдэнэт хотуудад “Ти Ди Би капитал” ХХК-ийн салбарыг нээх зөвшөөрлийг олгов.

5.1.4. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц

Хөрөнгийн биржийн арилжааны үзүүлэлтүүд: 2013 оны байдлаар нийт 254 удаагийн арилжаагаар 134 компанийн 65.8 сая ширхэг хувьцааг 97.6 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10.0 мянган ширхэг бондыг 1.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 98.6 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеийнхээс 46.1 тэрбум төгрөгөөр буюу 32 хувиар буурсан үзүүлэлттэй байв. Тайлант хугацаанд компанийн бондын болон анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй болно.


Арилжааны төрөл	Арилжигдсан үнэт цаасны тоо, ширхэг /сая ширхэг/	Үнийн дүн
Багцын арилжаа	33.8	83.2 тэрбум төгрөг
Тендер саналын арилжаа	11.7	2.5 тэрбум төгрөг
AON дуудлага арилжаа	99.8 мянган ширхэг	66.5 сая төгрөг

Тайлбар: /All or none/

Тайлант хугацаанд хувьцааны арилжааны өдрийн дундаж үзүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.62 хувиар буурч, өдөрт дунджаар 384.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаасны тоо, ширхэг нь нийт арилжсан ширхэгийн 99.11 хувь, үнийн дүнгийн 98.37 хувийг тус тус эзэлж байна.

График-13

Үнэт цаасны арилжааны хувь




Нийт 79 брокер, дилерийн компани “Монголын хөрөнгийн бирж” ХК-д гишүүнчлэлтэйгээс тайлант хугацаанд 56 компани үнэт цаасны арилжаанд оролцжээ. Үнэт цаасны гүйлгээний дүнгээр “Голомт секьюритиз” ХХК, “Би Ди Сек” ХК, “Ти Ди Би Капитал” ХХК, “Батс” ХХК, “Дэлгэрхангай секьюритиз” ХХК нар тэргүүлж байна.

Үнэт цаасны арилжааны дүн өмнөх оны мөн үеийнхээс буурсан шалтгаан нь Монгол улсын иргэдэд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэх арга хэмжээтэй уялдан иргэд Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшсэн хувьцаагаа арилжих үйл ажиллагаа идэвхжсэнээс бүртгэлтэй компаниудын төвлөрөл дээд цэгтээ хүрсэн, хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгдээгүйтэй хамааралтай.

Төлбөр, тооцооны үзүүлэлтүүд: 2013 оны байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар 196 харилцагчийн 1,914 удаагийн нийт 1,550.0 тэрбум төгрөгийн орлого, 2,481 харилцагчийн 4,383 удаагийн нийт 1,569.2 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн бөгөөд үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх арилжааны 4 банкаар дамжуулан банк хооронд 61.5 тэрбум төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний төлбөрийг тус тус гүйцэтгэжээ. Төлбөр тооцоо гүйцэтгэгч 4 банкаар хийгдсэн гүйлгээний дүнг графикаар үзүүлбэл:

Арилжааны төлбөр тооцоо



Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн мэдээлэл: Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 329 Хувьцаат компанийн 1.6 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 18.1 тэрбум ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас төрийн өмчит 36 Хувьцаат компанийн 15.4 тэрбум ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 Хувьцаат компанийн 29.0 сая ширхэг хувьцааг тус тус хадгалагдаж байна. Мөн 12 төрлийн 3.5 сая ширхэг компанийн бонд, 90 төрлийн 4.8 сая ширхэг Засгийн Газрын бонд тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 5

Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас /мянган ширхэгээр/

Үзүүлэлт	2011	2012	2013
Төрийн бус хувьцаа	2,555,045.0	2,665,629.0	2,595,868
Төрийн мэдлийн хувьцаа	15,356,933.0	15,499,721.0	15,483,022
Орон нутгийн оролцоотой компани	29,128.0	29,046	29,046
Нийт хувьцааны дүн	17,941,105.0	18,194,396	18,107,936
Засгийн Газрын хямдруулсан бонд	4,238.0	4,335.0	2,348
Компанийн бонд	3,233.0	693.6	2530.7
Нийт бондын дүн	7,471.0	5,028.0	4,879

Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас /мянган ширхэгээр/

Компанийн бонд	21.6	20.6	3,300.2
ЗГ-ын хямдруулсан бонд	1,000	1,293	2,531

Цаашид Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөр, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг бие даасан нэгжүүд гүйцэтгэхээр зохицуулагдсан болно.

Үнэт цаасны зах зээлд оролцогч хөрөнгө оруулагчдын бүтэц: Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжийн дансанд өссөн дүнгээр шинээр 775,323, холболтын 131,422 дансыг нээснээс дотоодын иргэний 771,042, гадаадын иргэний 1,724, дотоодын аж ахуйн нэгжийн 2,394, гадаадын аж ахуйн нэгжийн 163 данс байна.

2013 онд төвлөрсөн хадгаламжид шинээр 9,137 данс нээгдсэнээс дотоодын иргэн 8,948, гадаадын иргэн 108, дотоодын аж ахуйн нэгж 65, гадаадын аж ахуйн нэгжүүд 16 данс нээжээ. Тайлант хугацаанд 2,172 дансыг холболтоор нээсэн байна.

2013 онд хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх бүтцийг 2012 оны мөн үетэй харьцуулахад гадаадын аж ахуйн нэгжийн оролцоо 88 хувиар буурч, 2 хувь болсон бол дотоодын аж ахуйн нэгжийн эзлэх хувь 27.3 дахин өсч 82 хувьд хүрчээ.

График-15



График-16



Гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн арилжааны дүнд эзлэх хувь буурахад 2013 онд эдийн засгийн өсөлт саарч, уул уурхайн компаниудын хувьцааны үнэ ханшинд нөлөөлсөн, хөрөнгө оруулалтын тодорхойгүй эрх зүйн орчноос үүдэлтэйгээр гадаадын шууд хөрөнгө оруулалт 50 гаруй хувиар буурсантай холбон тайлбарлах боломжтой.

Гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтын оролцоо нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээг өсгөх, институциональ хөрөнгө оруулагчдын сонирхлыг өдөөх, төлбөрийн балансын голлогч бүрэлдэхүүн болох капиталын балансыг тэнцвэржүүлэх, урсгал балансын алдагдлыг нөхөх, эдийн засгийн бодит өсөлтийн боломжийг бүрдүүлэхэд шууд нөлөөтэй тул манайх шиг жижиг, өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг импортоор хангадаг улсын хувьд дээрхи үзүүлэлтийн чиг хандлагад ач холбогдлыг өгөх нь зүйтэй. Учир нь бидний хувьд гадаадын капиталыг өөрийн эдийн засагт таталгүйгээр бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих боломж бага байна.

Үнэт цаасны зах зээлийн эрхзүйн зохицуулалт, дэд бүтцийг сайжруулах замаар уул уурхай болон аж үйлдвэрлэлийн салбарт институциональ хөрөнгө оруулалтыг татах нь өсөлтийг бүрдүүлэх үндсэн арга болно.

5.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ


5.2.1. Даатгалын компаниуд

2013 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 251 даатгалын салбар, 3178 даатгалын төлөөлөгч, 20 даатгалын зуучлагч компани, 14 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3244 тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулсан. Эдгээрээс “Монгол даатгал” ХХК гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, “Ард даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК-иуд хамтарсан хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2012 оны мөн үеийнхээс 1.34 дахин нэмэгдсэн байна.

График 17

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо




Даатгагчийн нийт хөрөнгө: Тайлант оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 126.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2012 оны мөн үетэй харьцуулахад 18.8 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 3.1 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 20.3 хувийг эзэлж байна.

График 18

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2013 оны 4 дүгээр улиралд 109.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 16.8 тэрбум төгрөг буюу нийт

хөрөнгийн 13.3 хувийг эзэлж байгаа бол 2012 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 88.7 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 82.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 18.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.5 хувийг эзэлж байсан байна.

Хүснэгт 6

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	12.12.31		13.12.31		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	88 721,80	82,5	109583,3	86,69	20 861,50	1.80
Эргэлтийн бус хөрөнгө	18 883,20	17,5	16819,9	13,31	- 2 063,30	(1.80)
Нийт хөрөнгө	107 605,00	100	126403,2	100.00	18 798,20	

Тайлант оны эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 64.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 22.0 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 10.37 хувийг дансны авлага, үлдэх 2.83 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад эргэлтийн хөрөнгө 0.31 пунктээр, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 6.34 пунктээр тус тус өсч, дансны авлага 0.73 пунктээр, богино хугацаат хөрөнгө оруулалт 5.92 пунктээр тус тус буурсан байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 20861.4 сая төгрөгөөр өссөн нь Хорооны 2012 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох” тухай тогтоол хэрэгжиж байгаатай холбоотой юм.

Хүснэгт 7

Эргэлтийн хөрөнгө

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2012		2013		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	51870,4	58,46	74791,8	64,80	22921,4	6,34
Богино хугацаат хөрөнгө оруулалт	24772,2	27,92	15168,4	22,00	-9603,8	-5,92
Дансны авлага	9847,9	11,10	16601,3	10,37	6753,4	-0,73
Бусад эргэлтийн хөрөнгө	2231,4	2,52	3021,8	2,83	790,4	0,31
Эргэлтийн хөрөнгийн дүн	88721,9	100	109583,3	100	20861,4	

Даатгагчийн ер төлбөр ба эзэмшигчдийн өмч: Даатгалын компаниудын нийт ер төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, ер төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн оны эцсийн байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна.

График 19



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2009 оны 4 дүгээр улиралд 60.3 хувийг эзэлж байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 51.4 хувь, 2011 оны 4 дүгээр улиралд 44.5 хувь, 2012 оны мөн үед 44.84 хувь эзэлж, тайлант онд 45.4 хувь эзэлж байгаа нь “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдож тодорхой пунктээр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2008 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн өмнөх онд 4.85 хувь байсан бол тайлант онд 5.0 хувь болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 8

Эзэмшигчдийн өмч /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012		2013		Өөрчлөлт	
Өр төлбөр	5 217,00	4,85	6 320,40	5,00	1 103,40	0,15
Нөөц сан	48 252,60	44,84	58 769,80	46,49	10 517,20	1,65
Эзэмшигчийн өмч	54 135,40	50,31	61 313,10	48,51	7 177,70	- 1,80
Нийт дүн	107 605,00	100,00	126 403,30	100,00	18 798,30	-

Тайлант үеийн эзэмшигчдийн өмчийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 18798.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж ирсэн нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой байна.

Даатгалын хураамжийн орлого: Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2013 оны эцэст 93897.4 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өссөн байна.

Тайлант онд ердийн даатгалын компаниуд 92871.8 сая төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1025.6 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 14663.8 сая төгрөгөөр буюу 1.2 дахин, урт хугацааны даатгалын орлого 230.0 сая төгрөгөөр буюу 1.3 дахин тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 31508.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын орлого нийт даатгалын хураамжийн орлогын 26.6 хувийг эзэлж байна.

Даатгалын хэлбэрээр 2013 оны 4 дүгээр улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.47 дахин, хөрөнгийн даатгал 1.37 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.06 дахин, ачааны даатгал 1.3 дахин, барилга угсралтын даатгал 2.35 дахин, мал амьтдын даатгал 1.75 дахин, хугацаат амьдралын даатгал 1.16 дахин, тэтгэврийн даатгал 1.64 дахин, эрүүл мэндийн даатгал 1.57 дахин тус тус өсч, агаарын хөлгийн даатгал 18 хувиар, хариуцлагын даатгал 6 хувиар, санхүүгийн даатгал 25 хувиар, хуримтлалын даатгал 17 хувиар буурсан байна.

Хүснэгт 9

Даатгалын хэлбэр	12.12.31	13.12.31	Өөрчлөлт /+, /-
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	6201	9 107,10	1,47
1.2 Хөрөнгийн даатгал	18716,6	25 628,00	1,37
1.3 Автотээврийн хэрэгслийн даатгал	15342,9	15275,8	1,00
1.4 Ачааны даатгал	1392,9	1 810,20	1,30

1.5 Барилга угсралтын даатгал	1756,1	4 122,20	2,35
1.6 Газар тариалангийн даатгал		-	-
1.7 Мал амьтдын даатгал	441,1	770,80	1,75
1.8 Агаарын хөлгийн даатгал	8570	7 044,40	0,82
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		370,7	4,3
1.10 Хариуцлагын даатгал	7514,3	7 069,80	0,94
1.11 Санхүүгийн даатгал	1975	2 576,80	1,30
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	16298.1	16211.8	0,99
1.13 Зээлийн даатгал		2 191,70	-
1.14 Итгэлцлийн даатгал		6,60	-
1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал		-	-
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		-	-
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		686,00	-
2.1. Хугацаат амьдралын даатгал	326,7	379,30	1,16
2.3. Хуримтлалын даатгал	125,3	103,70	0,83
2.4 Тэтгэврийн даатгал	35,3	57,90	1,64
2.5. Эрүүл мэндийн даатгал	308,2	484,70	1,57
	79 003,50	93 897,40	1,19


График 20



2003 оноос хойш 2013 он хүртэл нийт орлогын өсөлт 87.5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, даатгалын хураамжийн орлого сүүлийн жилийн дунджаас огцом өссөн байна. Түүнчлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан байна. Даатгалын хураамжийн орлогын өсөлт мөн инфляци, үнийн өсөлтүүд нөлөөлсөн гэж үзэж болно.

Даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар харуулахад өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.03 пунктээр буурсан байна.

График 21



Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого нь сүүлийн жилүүдэд өссөн байдалтай харагдаж байна.

График 22



Тайлант онд нийт хураамжийн орлого 93.9 тэрбум төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 32.4 мянган төгрөгт хүрчээ. Энэ үзүүлэлт 2003 оноос хойш даруй 15.2 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 3.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын нөхөн төлбөр: 2013 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 26459.3 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 39.2 хувийг эзэлж байна.


Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.21 дахин, хөрөнгийн даатгал 1.3 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.13 дахин, ачааны даатгал 1.3 дахин, мал амьтдын даатгал 2.03 дахин, хариуцлагын даатгал 1.11 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 2.2 дахин, хуримтлалын даатгал 1.0 дахин, эрүүл мэндийн даатгал 2.14 дахин тус тус өсч, агаарын хөлгийн даатгал 74 хувиар, санхүүгийн даатгал 25 хувиар, хугацаат амьдралын даатгал 8 хувиар, тэтгэврийн даатгал 13 хувиар тус тус буурсан байна.

Даатгалын хэлбэр	12.12.31	13.12.31	Өөрчлөлт /+/ /-/
	Даатгалын нийт нөхөн төлбөр (сая.төг)	Даатгалын нийт нөхөн төлбөр (сая.төг)	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1781,3	2 155,50	1,21
1.2 Хөрөнгийн даатгал	1830,8	2 377,30	1,30
1.3 Автотээврийн хэрэгслийн даатгал	6568,4	7 442,90	1,13
1.4 Ачааны даатгал	195,3	260,20	1,33
1.5 Барилга угсралтын даатгал		79,80	
1.6 Газар тариалангийн даатгал			
1.7 Мал амьтдын даатгал	28,4	57,70	2,03
1.8 Агаарын хөлгийн даатгал	29,3	7,70	0,26
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал		97,8	-
1.10 Хариуцлагын даатгал	284,9	315,80	1,11
1.11 Санхүүгийн даатгал	1208,4	911,10	0,75
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	4790,9	10562,1	2,2
1.13 Зээлийн даатгал		1 932,10	
1.14 Итгэлцлийн даатгал			
1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
2.1 Хугацаат амьдралын даатгал	56,5	52,00	0,92
2.3 Хуримтлалын даатгал	78,5	78,40	1,00
2.4 Тэтгэврийн даатгал	6,9	6,00	0,87
2.5 Эрүүл мэндийн даатгал	57,3	122,90	2,14
	16 916,90	26 459,30	1,56

2013 онд даатгагчийн нөхөн төлбөр 26.5 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх үеэс 25.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн төлбөр тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.

Даатгалын нөхөн төлбөр

График 23



Даатгалын хохирлын харьцаа: 2013 оны 4 дүгээр улиралд даатгалын хохирлын харьцаа даатгалын салбарын дүнгээр 42.0 хувь болж 5 жилийн өмнөх үеийнхээс 8.5 пунктээр, өмнөх оны мөн үеэс 7.1 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

График 24



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирлын харьцаагаар нь харуулахад 2013 оны 4 дүгээр улиралд “Номин даатгал” ХХК 55.7 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна.


2013 онд даатгалын компанийн даатгалын хохирлын харьцааг өмнөх оныхтой харьцуулахад:

Хүснэгт 11

№	Даатгагчийн нэр	2012	2013	Өөрчлөлт /пункт/
1	“Ард даатгал” ХХК	37,8	41,1	3,28
2	“Бодь даатгал” ХХК	32,0	34,4	2,40
3	“Ган зам даатгал” ХХК	7,8	11,4	3,55
4	“Мандал даатгал” ХХК	18,5	37,6	19,11
5	“МИГ даатгал” ХХК	38,0	45,4	7,45
6	“Монгол даатгал” ХХК	41,9	50,2	8,24
7	“Гэр даатгал” ХХК	40,0	36,7	(3,29)
8	“Моннис даатгал” ХХК	13,5	12,3	(1,26)
9	“Мөнх даатгал” ХХК	15,4	26,5	11,06
10	“Номин даатгал” ХХК	36,8	55,7	18,93
11	“Нэйшнл лайф даатгал” ХХК	27,0	25,3	(1,72)
12	“Практикал даатгал” ХХК	31,1	46,4	15,33
13	“Тэнгэр даатгал” ХХК	35,6	36,9	1,33
14	“Соёмбо даатгал” ХХК	39,9	48,5	8,62
15	“Монре даатгал” ХХК	23,9	46,6	22,66
16	“УБ хотын даатгал” ХХК	27,8	27,8	-
17	“Хаан даатгал” ХХК	3,59	22,99	19,40
	Нийт дүн	34.9	42.0	7.1

Даатгагчийн ашигт ажиллагаа: 2013 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5287.8 сая төгрөг болсон нь өмнөх жилийн мөн үеийнхээс 2892.4 сая төгрөгөөр буурсан байна.

График 25



Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 717.8 сая төгрөгөөр буурсан нь дүрмийн сангаа хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж байгаатай холбоотой юм. Мөн алдагдалтай ажиллаж байгаа компаниудын хуримтлагдсан алдагдал нөлөөлж байна.

Даатгалын нөөц сан: Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 24.7 тэрбум төгрөг байсан бол 2013 оны эцэст 57.3 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 2.3 дахин нэмэгдсэн байна.

График 26



Давхар даатгал: 2013 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 26.0 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн дүнтэй гарсан байна.

График 27



Тайлант оны жилийн эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2012 оны мөн үеийнхтэй харьцуулахад давхар даатгалын хураамжийн хэмжээгээ “Ард даатгал” ХХК 1228.6 сая төгрөгөөр, “Тэнгэр даатгал” ХХК 2244.3 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 1458.2 сая төгрөгөөр, “Монгол даатгал” ХХК 2001.4 сая төгрөгөөр, “Мандал женерал даатгал” ХХК 2321.8 сая төгрөгөөр, “Моннис даатгал” ХХК 148.4 сая төгрөгөөр, “Монре даатгал” ХХК 54.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, “Бодь даатгал” ХХК 2763.5 сая төгрөгөөр, “Соёмбо даатгал” ХХК 949.8 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

2013 онд даатгалын компаниуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулах хандлага өсч өмнөх оны мөн үеийнхээс 1.25 дахин нэмэгдсэн байна

Албан журмын даатгал: Монгол Улсад авто тээврийн хэрэгсэл болон жолоочийн тоо жилээс жилд өсөхийн хэрээр замын хөдөлгөөний нягтрал нэмэгдэж зам, тээврийн ослын тоо, иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр байна. Улсын Их Хурлаас албан журмын даатгалын анхны хэлбэр болгож тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь даатгалтай эсэхээс үл хамааран зам, тээврийн осолд өртсөн гуравдагч этгээд буюу амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудад нөхөн төлбөр олгож, хариуцлагын даатгалын суурь амжилттай тавигдлаа.

Тайлант онд жолоочийн даатгалаар нийт 16.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч 10.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нөхөн төлбөр 5.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 416.6 мянган гэрээ байгуулагдсан байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 18.9 мянга байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн нийт тээврийн хэрэгслийн тоо, оношилгоонд орсон тээврийн хэрэгслийн тоо, татвар төлсөн тээврийн хэрэгслийн тоо, жолоочийн даатгалын гэрээний тоо дараах байдалтай байна:

График 28



Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан Даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Албан журмын даатгагчдын холбоо байгуулагдаж, Жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, программ хангамжуудыг боловсруулж нэвтрүүлэх, түүнийгээ суулган ажиллуулах сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийг бий болгон ажиллаж байна.

Урт хугацааны даатгалын хөрөнгө, эзэмшигчийн өмч: Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 4491.0 сая төгрөгөөр буюу 5.0 дахин нэмэгдсэн байна.

График-29



Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.


Урт хугацааны даатгалын орлого, давхар даатгал: Урт хугацааны даатгалын компани 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 1025.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 64.6 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 259.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 1.3 дахин, нөхөн төлбөр 1.3 дахин, давхар даатгал 1.4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12

Он	2009	2010	2011	2012	2013
Хураамжийн орлого /сая төг/	115.3	285.2	510.3	795.6	1025.6
Давхар даатгал /сая төг/		107.0	94.7	44.7	64.6
Нөхөн төлбөр/сая төг/		45.7	69.9	199.3	259.3

Тус компанийн даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөр 2010 оноос тогтмол нэмэгдэж ирсэн байна.

График-30



Урт хугацааны даатгалын ашигт ажиллагаа, нөөц сан: Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ одоогийн байдлаар 807.5 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 20.0 хувийг эзэлж байна.

Он	2009	2010	2011	2012	2013
Өр төлбөр / сая төг/	115.6	180.5	228.5	64,6	82,1
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1000.0	2000.0	3350.0	3350.0	4000.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-331.1	-474.6	-655.4	-770.3	-861.1
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-191.5	-142.5	-180.7	-114.9	-75.4
Нөөц сан	8.6	93.1	287.5	566.1	933.1

Хүснэгт 14
/сая төгрөгөөр/

Даатгалын нөөц	2009	2010	2011	2012	2013
Хувь оролцоотой гэрээний нөөц сан					
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан		46.9	287.5	566.1	933.1
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан					
ДҮН	-	46.9	287.5	566.1	933.1

Даатгалын нөөц сан 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 810.7 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 354.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд өмнөх 4 жилийн мөн үеийнхээс 11.7 дахин нэмэгдсэн байна.


5.2.2. Даатгалын мэргэжлийн оролцогч байгууллага

Даатгалын зуучлагч: Тайлант оны 4 дүгээр улиралд нийт 20 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 1451.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн байна.

Даатгалын зуучлалын орлого /Сүүлийн 3 жилээр/

График 31


Даатгалын зуучлалын хураамжийн орлого



Нийт хураамжийн орлогын 33.7 хувийг “Эрсдлийн шийдэл” ХХК нь дангаараа бүрдүүлсэн байна. “Төрийн банк” ХХК, “Эй эс ай би” ХХК, “Хүннү сэйл” ХХК-иуд үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа тул даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч: Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 462.4 сая төгрөг болсон байна.

Даатгалын хохирол үнэлэгчийн хураамжийн орлого



2013 оны тайлант үеийн хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 компанийн даатгалын хохирол үнэлгээний орлого 1.4- 24 дахин өссөн байна. Тайлант хугацаанд “Тэгш сонголт эстимэйт” ХХК нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.


5.3. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

5.3.1. Банк бус санхүүгийн байгууллага

2013 онд 54 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 263 банк бус санхүүгийн байгууллага банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба 232 буюу 88.2 хувь нь Улаанбаатар хотод, 31 буюу 11.8 хувь нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Банк бус санхүүгийн байгууллагын 2000 оноос хойшхи хугацааны тооны өөрчлөлтийг үзүүлбэл:

График 33



Банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж буй үйл ажиллагаа болон үйлчилгээний нэр төрөл дараах байдалтай байна:

Хүснэгт 15

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг нийт	104
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	41
2	Зээл	219

3	Факторингийн үйлчилгээ	13
4	Төлбөрийн баталгаа гаргах	9
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5
7	Итгэлцлийн үйлчилгээ	21
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	21
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0

Нийт Банк бус санхүүгийн байгууллагын 83.3 хувь нь зээл, 39.5 хувь нь гадаад валютын арилжаа /15.6 хувь нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг/, 8.0 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.9 хувь нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.9 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.4 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 8.0 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.8 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлдэг.

2013 оны жилийн эцсийн байдлаар салбарын ерөнхий статистик үзүүлэлт дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 16


№	Үндсэн үзүүлэлтүүд	2013 оны жилийн эцэс
1	Банк бус санхүүгийн байгууллагын тоо	263
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	762
3	Ажиллагсдын тоо	1,396
4	Салбар нэгжийн тоо	84
5	Харилцагчдын тоо	2,050,590
6	Нийт актив /мянган төг/	381,130,752.7
Банкны салбарт эзлэх хувь		1.82%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төг/	223,711,713.9
Банкны салбарт эзлэх хувь		2.06%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төг/	234,337,952.6
Банкны салбарт эзлэх хувь		17.70%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төг/	183,691,627.8
Банкны салбарт эзлэх хувь		50.59%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төг/	19,074,014.6
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төг/	90,226,226.1
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төг/	63,470,381.0
	Урт хугацаат зээл /мянган төг/	26,755,845.1
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төг/	11,917,167.1
13	Нийт орлого /мянган төг/	106,652,086.0
14	Нийт зардал /мянган төг/	76,817,416.8
15	Тайлант үеийн ашиг /мянган төг/	29,834,669.3

2013 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын нийт актив оны эхнээс 51.2 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 45.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн. Тухайлбал, тайлант хугацаанд нийт 19.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 54 банк бус санхүүгийн байгууллага шинээр тусгай зөвшөөрөл авсан, тайлант хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөлтэй байсан Банк бус санхүүгийн байгууллагуудад нийт 25.9 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцдээ өөрчлөлт оруулсан буюу нэмэлт хөрөнгө оруулалт, хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлжээ.

Тусгай зөвшөөрөлтэй 263 банк бус санхүүгийн байгууллага нь 381.1 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба активын өсөлт нь 2012 оны жилийн эцсээс 51.2 хувиар өссөн байна.


Нийт активын 96.7 хувь нь эргэлтийн хөрөнгө, 3.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна:

График 34




Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр буюу 8.8 хувийн үзүүлэлттэй байсан бол сүүлийн 4 жилийн хугацаанд буурч 2013 оны жилийн эцэст 3.8 хувьд хүрсэн.

График 35



Зээлийн багцын чанар: 2013 оны жилийн эцэст зээлийн өрийн үлдэгдэл 223,7 тэрбум төгрөгт хүрсэн. Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр буюу 8.8 хувийн үзүүлэлттэй байсан бол сүүлийн 4 жилийн хугацаанд буурч 2013 оны жилийн эцэст 3.8 хувьд хүрсэн.

График 36




Зээлийн хүү: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 263 банк бус санхүүгийн байгууллагаас 219 буюу 83.3 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Зээлийн сарын хамгийн дээд хүү 9.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын дундаж дээд хүү 4.02 хувь, зээлийн дундаж доод хүү 2.23 хувь буюу нийт Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын дундаж хүү 3.13 хувь байна.

Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.


График 37



Нийт эх үүсвэр, бүтэц: 2013 оны жилийн эцэст нийт эх үүсвэрийн 38.5 хувийг нийт өр төлбөр, 61.5 хувийг эзэмшигчдийн өмч эзэлсэн байна.

Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь банк бус санхүүгийн байгууллагуудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ өссөнтэй холбоотой. Өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн өсөлтөнд банк бус санхүүгийн байгууллагын тоо нэмэгдсэн, дүрмийн сандаа оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой юм.


График 38



Ашигт ажиллагаа: Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна:

График 39

ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА /тэрбум төгрөгөөр/




Тайлант жилийн эцэст салбарын ашигт ажиллагаа өмнөх оноос 62 хувиар нэмэгдсэн нь активын өсөлт, Банк бус санхүүгийн байгууллагын тооны өсөлт, тэдгээрийн үйл ажиллагаа сайжирсантай холбоотой байна.

5.3.2. Хадгаламж, зээлийн хоршоо

2013 онд хадгаламж, зээлийн 2 хоршоонд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 9 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 141 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхэлж байгаа ба 57 буюу 40.4 хувь нь Улаанбаатар хотод, 84 буюу 59.6 хувь нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын болон гишүүдийн тооны өөрчлөлтийг сүүлийн 8 жилийн байдлаар харуулбал:

График 40



2013 оны тайлант хугацааны эцсийн байдлаар салбарын ерөнхий статистик үзүүлэлт дараах байдалтай байна.


№	Үндсэн үзүүлэлтүүд	2012оны IV улирал	2013оны IV улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Хадгаламж, зээлийн хоршоодын тоо	148	141	(7)	-4.7
2	Гишүүдийн тоо	26,004	27,245	1,241	4.8
3	Нийт актив	67,715,372.3	73,836,256.6	6,120,884.2	9.0
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.4%	(0.0)	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	48,323,993.7	49,374,352.1	1,050,358.4	2.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.5%	(0.0)	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,061,317.1	1,545,393.8	484,076.7	45.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.3%	(0.4)	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	47,085,939.6	50,681,959.1	3,596,019.5	7.6
	Банкны салбарт эзлэх хувь	1.1%	0.8%	(0.1)	
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9,441,815.2	9,786,928.9	345,113.7	3.7
	Банкны салбарт эзлэх хувь	3.4%	*		
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	6,947,309.0	8,658,919.5	1,711,610.5	24.6
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	968,120.3	417,588.9	(550,531.4)	-56.9
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	533,467.4	532,711.6	(755.8)	-0.1
11	Нийт орлого	16,554,324.3	17,567,984.8	1,013,660.5	6.1
12	Нийт зардал	12,713,905.5	13,498,669.2	784,763.7	6.2
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	3,840,418.8	4,069,315.6	228,896.8	6.0

Нийт актив: 2013 онд хадгаламж, зээлийн хоршоодын тоо буурсан ч гишүүдийн тоо оны эхнээс 4,8 хувиар, нийт активын хэмжээ 9 хувиар өссөн бөгөөд активын 66.9 хувийг зээлийн багц эзэлж байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг харуулбал:

График 41

ХЗХ -дын голлох үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/



Зээлийн багцын чанар: 2013 оны байдлаар хадгаламж зээлийн хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл 49,4 тэрбум төгрөг хүрсэн бөгөөд цэвэр зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,8 тэрбум төгрөгөөр буюу 1.8 хувиар, чанаргүй зээлийн үлдэгдэл 0,5 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Салбарын хэмжээгээр нийт зээл, зээлийн чанарыг графикаар харуулбал:

График 42



Хадгаламж: Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өсөж, банкны салбарын 0.8 хувийг эзэлж байна. Нийт мөнгөн хадгаламжийн 95.5 хувь нь хугацаатай, 4.5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.


График 43



Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт эх үүсвэрийн 68.6 хувийг эзэлж байгаа бөгөөд хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500.0 сая төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 хоршооны 44,6 тэрбум төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл нь салбарын 88.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.

График 44



Гишүүдийн хувь хөрөнгө: Тайлант жилийн байдлаар хувь хөрөнгийн хэмжээ 9,8 тэрбум төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 13.3 хувийг эзэлж байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2,6 тэрбум төгрөгөөр өсч 19,0 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 18
/мянган төгрөгөөр/

д/д	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгийн дүн	Нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь
1	2,000,000.0 дээш	1	5,542,459.2	29.1%
2	500,000.0-1,000,000.0	6	5,502,327.1	28.9%
3	100,000.0-500,000.0	21	4,095,903.6	21.5%
4	50,000.0-100,000.0	26	1,913,710.0	10.1%
5	10,000.0-50,000.0	61	1,797,419.3	9.4%
6	1,000.0-10,000.0	26	170,136.2	0.9%
	Нийт өөрийн хөрөнгийн дүн	141	19,021,955.4	100.0%

Хадгаламж, зээлийн хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор активын хэмжээгээр нь 4 ангилж бүлэглэвэл:

Хүснэгт 19

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ-ны тоо	ХЗХ-нд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	58	41.1%	1.8%	17	41
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	68	48.3%	15.4%	29	39
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	5	3.5%	4.9%	2	3
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	10	7.1%	77.9%	9	1
	Нийт дүн	141	100.0%	100.0%	57	84

Ашигт ажиллагаа: 2013 оны байдлаар хадгаламж, зээлийн хоршоод нь салбарын хэмжээнд 17.6 тэрбум төгрөгийн орлого олж, 13.5 тэрбум төгрөгийн зардал гаргаж 4.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан ба ашгийн түвшин 5.6 хувьтай байна.

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА, САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

6.1. Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа:

Хөдөө аж ахуйн бирж 2013 оны 4 дүгээр сараас ямааны ноолуурыг шууд арилжих гэрээний /СПОТ/ төрлөөр анхны арилжааг хийж эхэлсэн ба 2013 оны дүнгээр ямааны ноолуур, хонины ноос, тосны ургамал /рапс/, тэмээний ноос гэсэн нэр төрлийн бараа, түүхий эдийн нийт 132 удаагийн арилжааг зохион байгуулж, нийт 404.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, хэлцлийг баталгаажуулжээ.


Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч Улаанбаатар хотод 17, орон нутагт 17 байгуулагдаж үйл ажиллагаа эрхэлж байна.

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ыг баталж, нөхцөл шаардлагыг хангасан нийт 34 хуулийн этгээдэд хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн нэр төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор 30 арилжааны зуучлагч/брокер/-дад хонины ноос, 13 арилжааны зуучлагч /брокер/-дад тосны ургамал /рапс/ гэсэн бараа, түүхий эдийн нэр төрлөөр тусгай зөвшөөрлийг тус тус нэмж олгосон.

Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан бараа, түүхий эдийн нэр төрөл, ангиллаар нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 6,406.0 тн ямааны ноолуурыг 385.7 тэрбум төгрөгөөр,
- 1,005 тн хонины ноосыг 1.5 тэрбум төгрөгөөр,
- 1,048 тн тэмээний ноосыг 5.0 тэрбум төгрөгөөр,
- 14,912.0 тн тосны ургамал /рапс/-ыг 11.8 тэрбум төгрөгөөр,

График 45



Хөдөө аж ахуйн биржээр нийт 404.1 тэрбум төгрөгийн бараа, түүхий эдийн арилжаа хийгдсэн нь далд эдийн засгийг ил болгоход чиглэгдсэн төрийн бодлого хэрэгжиж, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид/ченж/-ийн гар дээр далд эргэлдэж, санхүүгийн тайлан мэдээнд тусгагдаж байгаагүй их хэмжээний мөнгө ил болсон.

“Хөдөө Аж Ахуйн Бирж” ТӨХХК-ийн үндсэн үйл ажиллагаанд шалгалт хийж, биржийн гишүүнчлэл, арилжааны горим, техник, программ хангамж, санхүүгийн болон боловсон хүчний чадавхитай танилцлаа. Шалгалтын тайланг Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хороо, Биржийн зохицуулах зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлээд байна.

6.2. Компанийн засаглал:

Монгол Улсын Засгийн Газраас Компанийн Засаглалын Үндэсний Хөтөлбөрийг баталж уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах, түүнд хяналт тавих үүрэг бүхий Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллагуудын

оролцоотойгоор байгуулсан. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь Зөвлөлийн хурал бөгөөд өөрийн Ажлын албатай. Энэ алба нь тус Хорооны бүтцэд багтдаг.

2013 онд Компанийн засаглалын үндэсний тайланг боловсруулж Монгол Улсын Засгийн Газрын өмнө тайлагнах, олон нийтэд мэдээлэх ажлыг хийлээ.

Тайланд Монголын компанийн засаглалын хөгжлийн түүх, өнөөгийн байдал болон олон улсын туршлага гэсэн үндсэн гурван бүлгийн хүрээнд хувьцаат компани, гэр бүлийн компани, төрийн өмчит хувьцаат компани, банк, хадгаламж, зээлийн хоршоод, даатгал болон банк бус санхүүгийн байгууллагуудын компанийн засаглалыг тодорхой судалгаа, үнэлэлт дүгнэлтийг үндэслэн боловсруулсан.

Компанийн засаглалын үндэсний 6 дахь удаагийн форумыг “Банк, даатгалын компанийн засаглал” сэдвээр Компанийн засаглалын хөгжлийн төв, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран зохион байгуулж, тус салбарын засаглалын олон улсын туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэн нийт 200 гаруй хүнийг хамрууллаа.

Компанийн засаглалын талаар Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудад зориулан “Төрийн сайн засаглалыг бэхжүүлэх нь” сэдэвт засаглалын семинар, Компанийн засаглалын үндэсний зөвлөл, түүний Ажлын албанаас Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголбанкттай хамтран Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр ТОП-20 хувьцаат компаниудын болон арилжааны банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтыг тус тус зохион байгуулсан.

Хадгаламж, зээлийн хоршоодод “Хадгаламж, зээлийн хоршоодын засаглалын мөн чанар, сайжруулах арга хэмжээ” сэдвээр, аудитын байгууллага болон арилжааны банкуудад “Хяналтын орчин”, “Компанийн Засаглал ба түүний ач холбогдол” сэдвээр тус тус семинар зохион байгуулж компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр заавар зөвлөгөө өглөө.

2013 оны байдлаар нийт 39 удаагийн сургалт зохион байгуулж 944 төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг хамруулж гэрчилгээ олгосон бөгөөд өнөөдөр улсын хэмжээнд нийт 1480 хүн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

Гадаадын компаниудын жишиг засаглалын үйл ажиллагаатай танилцах туршлага солилцох зорилгоор Азийн компанийн засаглалын холбооноос зохион байгуулсан “Азийн компанийн засаглал” сэдэвт семинарт оролцож, Азийн орнуудын компанийн засаглалын хөгжил, БНСУ-ын компанийн засаглалын хөгжлийн тогтвортой байдлын тухай илтгэл сонсож, Солонгосын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын компанийн засаглалын санаачилга, зөвлөмжийн талаар харилцан ярилцаж санал бодлоо солилцсон.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас Монгол улсын Засгийн Газартай хамтран зохион байгуулдаг ТОП-150 аж ахуйн нэгжийн шалгаруулалтад Компанийн нийгмийн хариуцлагын эзлэх хувийн жинг 25 хувь болгон өсгөж компаниудын энэ чиглэлийн идэвх санаачилгыг өрнүүлэхэд анхаарч ажилласан бөгөөд компанийн засаглалын үнэлгээ хийх аргачлал боловсруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох чиглэлээр Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран ажиллаж эхлээд байна.

2013 онд Монголын анхны ТОП-20 хувьцаат компанийн засаглалын үнэлгээний тайланг хийлээ. Тайлангаар Монголын компаниудыг өрсөлдөх чадвар болон гүйцэтгэлээ сайжруулах, хөрөнгө оруулалт татах, Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахын тулд компанийн засаглалаа сайжруулах талаар зөвлөмж гаргасан байна.

Компанийн засаглалын ил тод нээлттэй байдлыг бий болгох мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын хүрээнд “Монголын эдийн засаг” сэтгүүлтэй харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан тус сэтгүүл дээр Компанийн засаглалын булан нээн мэдээллийг хүргэж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох, түүнд тавигдах шаардлага, зохистой удирдлага, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зэрэг засаглалын асуудлуудыг тусгаж орууллаа.

Мөн Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд засаглалын зарчимтай холбоотой зарим зүйл заалтыг тусгуулсан ба уг хууль хэлэлцүүлгийн шатандаа явж байна.

Үнэт цаасны болон Компанийн тухай хуулиудад нийцүүлэн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны, нарийн бичгийн даргын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх, аудитын, хорооны, хувь нийлүүлэгчдийн хурлын үлгэрчилсэн журмуудыг боловсруулан батлав.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журмыг нэмж сайжруулах зорилгоор Төрийн өмчийн хороо, Компанийн засаглалын Үндэсний зөвлөлтэй хамтран байгуулсан ажлын хэсэгт орж ажилласан.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу Компанийн засаглалын кодексын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлгийг Гишүүн байгууллагууд, Монголбанк, “Монголын хөрөнгийн бирж” ХК, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн гишүүд, Хамтын ажиллагааны санамж бичигт нэгдсэн байгууллагууд, Хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага, Банк, банк бус санхүүгийн болон даатгалын компаниудын төлөөлөл, Олон улсын байгууллагын төлөөлөл, Аудитын компанийн төлөөлөл, Хадгаламж, зээлийн хоршоод, Төрийн өмчит компаниудын дунд хэлэлцүүлэг явуулж, гарсан саналуудыг Компанийн засаглалын кодексын шинэчилсэн найруулгад тусгаад байна.

Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эдийн засгийн хөгжлийн яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөртэй хамтран Германы нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичгийг судалж танилцуулга бэлтгэн Эдийн засгийн хөгжлийн яамны Монгол улсын компанийн нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг боловсруулан гаргах ажлын хэсэгт хүргүүлээ.

Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд “Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах” тухай хуулийн төслийн талаар Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд “Хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийн талаархи бусад орнуудын туршлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

6.2. Зээлийн батлан даалтын сан:

Засгийн Газрын 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий Зээлийн батлан даалтын сан 2012 онд үүсгэн байгуулагдаж, улмаар 2013 оны 4 дүгээр сард албан ёсны нээлтээ хийж, мөн оны 5 сараас анхны батлан даалтын шийдвэрийг гаргасан.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Сангийн тогтвортой үйл ажиллагааг хангах, эрсдэлийн санг байгуулах зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам, Сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлийн батлан даалтыг гаргаж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. Батлан даалтын хугацааны хувьд зээлдэгч болон банк, санхүүгийн байгууллага хооронд байгуулсан зээлийн гэрээний хугацаанаас хэтрэхгүйгээр журамласан.

Сан нь 2013 онд 56 иргэн, хуулийн этгээдийн 10 тэрбум төгрөгийн зээлд 3.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаснаар 498 ажлын байр хадгалагдаж, 212 ажлын байр шинээр нэмэгдэх

боломжийг бүрдүүлээд байгаа бөгөөд арилжааны 7 банк, 1 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Батлан даалт гаргасан байдлыг орон нутгаар нь авч үзвэл:

Хүснэгт 20

Аймаг, хот	Батлан даалтын тоо	Хувь
Улаанбаатар	42	75.00%
Дорнод	4	7.14%
Төв	2	3.57%
Баянхонгор	1	1.79%
Дархан-Уул	1	1.79%
Дундговь	1	1.79%
Орхон	1	1.79%
Өвөрхангай	1	1.79%
Сэлэнгэ	1	1.79%
Ховд	1	1.79%
Хэнтий	1	1.79%
Дүн	56	100.00%

Нийт батлан даалтын 75 хувь буюу 42 нь Улаанбаатар хотод, 18.6 хувь буюу 14 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, иргэд байна.

Батлан даалт гаргуулсан аж ахуйн нэгж иргэдийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл:

Хүснэгт 21

Үйл ажиллагааны төрөл	Батлан даалтын дүн	Хувь
Үйлдвэрлэл	2,577,270,000	69.63%
Үйлчилгээ	137,742,000	3.72%
Хөдөө аж ахуй	834,000,000	22.53%
Худалдаа	152,320,000	4.12%
Дүн	3,701,332,000	100.00%

Батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан харилцагчдын 70 хувийг үйлдвэрлэл, 22.5 хувийг хөдөө аж ахуй, 7.84 хувийг худалдаа үйлчилгээ эрхлэгчид тус тус эзэлж байна.

6.4. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт: Онцгой албан татварын тухай, Ашигт малтмалын тухай хуулиудад ногдуулах онцгой албан татварын хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэргийг гадаад валютаар илэрхийлсэн нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуультай нийцэхгүй байгаа тул холбогдох хуулиудад онцгой албан татварын хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэргийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэхээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хорооноос Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд нийт 41 хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж, хууль зөрчсөн 14 хуулийн этгээдэд нийт 134,4 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулсан.

Төсвийн орлого, хураамжийг гадаад валютаар төвлөрүүлэх нь дээрх хуулийг зөрчсөн үйлдэл болж байсан тул төсвийн орлого, хураамж төвлөрүүлдэг банкин дахь гадаад валютын харилцаа дансыг хаах асуудлыг Сангийн яамтай хамтран шийдвэрлэлээ.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг олон нийтэд сурталчлах, хуулийг зөрчин ажил үйлчилгээ явуулж буй хуулийн этгээдийн талаар гомдол санал хүлээн авах зорилгоор цахим хуудас <http://mnt.frc.mn/> нээж ажиллуулж байна.

6.5. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа: Үнэт цаасны зах зээлд оролцогч хувьцаат компаниуд болон өрийн бичиг арилжих компаниудын санхүүжих чадавхын зэрэглэлийг тогтоох мэргэжлийн байгууллагууд бий болгох, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах санхүүжих чадавхын зэрэглэлийн тогтолцоог санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх зорилгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлэн Хорооноос “Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг баталсан. Санхүүжих чадавхын зэрэглэлийн тогтолцоог санхүүгийн зах зээлд нэвтрүүлснээр хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргахад ашиглах бодит эх сурвалжийг бий болгох, эрсдэлийн үнэлгээний шинэ дэд бүтэц бий болгоход чухал алхам болох юм.

Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох мэргэжлийн байгууллага нь Хороонд үнэт цаасаа бүртгүүлсэн, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан компанийн үнэт цаасны санхүүжих чадавхын зэрэглэл буюу үнэт цаасны зэрэглэл /securities rating/ тогтоох үйлчилгээ үзүүлнэ. Зэрэглэл тогтоох байгууллагын зэрэглэл тогтоох аргачлал, үйл ажиллагаа нь олон улсын стандартад нийцсэн, харилцагч, хөрөнгө оруулагч, зах зээлийн эрх ашгийг хамгаалсан, ил тод байх ба зэрэглэл тогтоох байгууллага нь хараат бусаар үйл ажиллагаа явуулж, өөрийн бизнесийн нэр хүндээрээ зах зээлд шударгаар өрсөлдөх этгээд байхаар зохицуулсан.

ДОЛОО. ХОРООНООС 2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ГОЛ АЖЛУУД

Санхүүгийн зохицуулах хороо 2014 онд өөрийн зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарт дараах ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

Өнгөрсөн онд зах зээлийн мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр “Санхүүгийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”/2014-2016/-ийг боловсруулахаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлд заасан. Энэ ажлыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор өөрийн зохицуулалтад хамаарах санхүүгийн салбаруудыг хөгжүүлэх хөтөлбөрийн эхний хувилбарыг боловсруулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Мөн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр/2014-2020/-ийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсрол шинжлэх ухааны яам, Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтран боловсруулахаар заасан. Энэ ажлыг эхлүүлэх зорилгоор Хороо дотоодын ажлын хэсэг байгуулан ажиллуулж эхэлсэн. Уг хөтөлбөрийг бэлэн болгох, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

Үнэт цаасны салбарт 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг өнгөрсөн хугацаанд мөрдөж ажилласан. Үүгээр компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх, хувьцаат компаниар бүртгэлийн шаардлага хангуулах, Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг зах зээлд оролцогчид болон олон нийтэд таниулах, мөрдүүлэх, холбогдох салбарын хуулиудыг хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийгдлээ.

2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудад нийцүүлэн үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд нийт зохицуулалтын 21 журмыг боловсруулав. 2014 онд эдгээр журмуудыг улам боловсронгуй болгох, шаардлагатай журмуудыг шинээр боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Эдгээр журмыг баталснаар хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, үнэт цаасны зах зээл дэх хариуцлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх зүйн орчныг улам сайжруулна гэж үзэж байгаа бөгөөд зах зээлийн эрсдлийг бууруулах нөхцлийг бүрдүүлж, мэргэжлийн зуучлалын сонгодог үйлчилгээг үзүүлэх санхүү, хүний нөөц, техник, технологийн шийдлийн тусламжтайгаар үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг сайжруулахаар түүштай ажиллана.

Үнэт цаасны салбарт 2013 онд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд онцгой анхаарч ажилласан ба ялангуяа 2014 онд шинэ хуулиудад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлүүд болох хадгаламжийн бичиг, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, кастодианы үйлчилгээ, институциональ хөрөнгө оруулалтын дэд бүтцийг төлөвшүүлснээр зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар огцом нэмэгдэх бололцоог хангаж ажиллана.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хуулийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс өнгөрсөн онд хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүйгээс төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх нь дуусгавар болсон нийт 130 хувьцаат компанийн арилжааны банкууд дах дансаар дамжуулан мөнгөн төлбөр тооцоо хийх эрхийг түр зогсоох ажлыг хэрэгжүүлэв. Мөн сүүлийн гурван жил дараалан Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаас гаргагчдын үүргээ биелүүлээгүй, хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуурыг хангаагүй 69 хувьцаат компанийн үнэт цаасыг биржийн бүртгэлээс хасах үйл ажиллагааг гүйцэтгэв.

Хувьцаат компаниудын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд онцгой анхаарч эдгээр компаниудад шаардлага тавьж, үүргээ биелүүлээгүй компаниудад хариуцлага хүлээлгэж ажиллана.

2013 оны байдлаар Хөрөнгийн биржид 261 компани бүртгэлтэйгээс, төрийн өмчийн оролцоотой 30, төрийн өмчит 23, хувийн өмчит 208 компани байна. Цаашид нээлттэй компанийн нэр хүндийг өсгөх, тэдгээрийг татварын бодлогоор дэмжих, биржийн бүртгэлийн шаардлагыг өндөрсгөхөд анхаарч ажиллана. Энэ ажлын хүрээнд Төрийн өмчийн хороотой хамтарч хувьцаат компаниудын талаарх төрийн байгууллагуудад хөтөлгөж буй бүртгэлийг тулгаж цэгцлэх, зарим төрийн өмчит компаниудын үнэт цаасыг бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангав.

Хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх нь бидний үндсэн зорилт билээ. Гадаад эдийн засгийн таагүй нөлөөгөөр 2013 онд манай улсын экспортын эрэлт болон үнэ буурч, гадаад валютын дотогшлох урсгал багасч, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс эдийн засгийн өсөлт саарсан билээ. Үүний үр дүнд санхүүгийн зуучлал хумигдаж, эдийн засагт сөргөөр нөлөөлөв. Тухайлбал, эдийн засгийн өсөлт саарч, уул уурхайн компаниудын хувьцааны үнэ ханшинд нөлөөлсөн, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан зэргээс хамаарч үнэт цаасны зах зээлийн үнэлгээ өмнөх онуудтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байв.

Иймд бид 2014 онд зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх чиглэлээр төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьчлалыг Хөрөнгийн биржээр явуулах, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч гадаадын бирж дээр хувьцаагаа гаргасан компаниудыг давхар бүртгэх, цаашид шинээр гадаадын хөрөнгийн зах дээр үнэт цаас гаргах компанийн тодорхой хувийг дотоодын бирж дээр арилжаалах, бүртгэлтэй компанийн төвлөрлийг задлах зэрэг бүртгэлийн нэр хүнд, ач холбогдлыг дэмжиж ажиллана.

2013 онд Компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу Компанийн засаглалын кодексын шинэчилсэн

найруулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлгийн хүрээнд гарсан саналуудыг Компанийн засаглалын кодексын шинэчилсэн найруулгад тусгаад байна. Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд “Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах” тухай хуулийн төслийн талаар Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд “Хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийн талаархи бусад орнуудын туршлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Цаашид Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Компанийн нийгмийн хариуцлагын үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх шатны ажлууд хийгдэнэ.

Даатгалын салбарын хөгжлийн хэтийн төлөвийг дунд хугацаанд тодорхойлох, даатгалын салбарын бодлого, зохицуулалт, хяналт шалгалтыг олон улсын стандартад нийцсэн чиглэлээр хөгжүүлэх зорилгоор “Даатгалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны /2014-2017/ хөтөлбөр”-ийг холбогдох яамд, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж батлуулах шаардлагатай байгаа бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэхээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Монгол Улсын даатгалын салбарт гарсан томоохон дэвшил нь албан журмын даатгалын анхны хэлбэр болох жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоог нэвтрүүлж Улсын Их Хурлаас 2011 онд Жолоочийн даатгалын тухай хуулийг баталсан явдал юм. Ингэснээр замын хөдөлгөөний нягтрал ихэсч, зам тээврийн ослын тоо, иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдэж байгаа өнөө үед замын хөдөлгөөнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн. Цаашид албан журмын даатгалын шинэ хэлбэр, тухайлбал эмчийн хариуцлагын даатгал, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал, тээвэрлэгчийн хариуцлагын даатгалын хууль эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэхээр ажиллаж байна.

Амьдралын даатгалын үйл ажиллагааг дэмжих, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох, нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалтай амьдралын даатгалыг уялдуулан хөгжүүлэх асуудлаар Даатгалын тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгаж оруулах чиглэлээр ажиллаж байна.

2013 оны жилийн эцсийн тайлангаар гадаадын давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж 26 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд даатгалын хураамжийн орлогын өсөлттэй адил хамаарлаар жил бүр өсч байна. Иймд нэг талаас валютын гадагш чиглэсэн урсгалыг хааж багасгах, нөгөө талаас дотоод дахь давхар даатгалын чадавхийг төлөвшүүлэх зорилгоор үндэсний давхар даатгалын компани байгуулах шаардлагатай байна. Энэ зорилтын хүрээнд Дэлхийн банкны төслийн зөвлөхийг урьж ажиллуулан, тайланг хүлээж аваад байна.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын компанийн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг 2016 он гэхэд ердийн даатгалын компанийн хувьд 5 тэрбум төгрөг, урт хугацааны буюу амьдралын даатгалын компанид 6 тэрбум төгрөг, давхар даатгалын компанид 15 тэрбум төгрөгт хүргэж нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2014 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Компанийн засаглалын асуудлаар даатгалын компаниудаас нийт 55 асуултаар асуулга авч судалж үзэхэд зарим даатгалын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлын албан тушаалыг нэг хүн хийх, төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнгүй, үр дүнтэй, тогтмол үйл ажиллагааг явуулж чадахгүй зэрэг дутагдал илэрсэн тул энэ чиглэлээр зохицуулалт, хяналтыг сайжруулахаар төлөвлөж байна.

Даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, даатгалын хохирлын үнэлгээний стандартыг бий болгох, даатгалын актуарч, андеррайтер зэрэг мэргэжлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах, татварын тогтолцоогоор дамжуулан даатгалын салбарыг дэмжих зэрэг асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахаар төлөвлөж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар өргөн бариулж, батлуулах нь бичил санхүүгийн салбарын эн тэргүүний зорилтын нэг юм. Уг хуулийн төслөөр төр засгаас баримталж буй тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлэх, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой ажлыг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх, тусгай зөвшөөрөл олгохоос эхлэн хүчингүй болгох хүртэл бүхий л үйл ажиллагааг хөнгөвчлөх, тодорхой болгох зохицуулалтыг бий болгоно. Мөн төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх Төрөөс банк бус санхүүгийн үйл ажиллагаанд хийх хяналт, зохицуулалтыг тодорхой болгох зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Иймд уг хуулийн төслийг 2014 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулахад анхаарч ажиллана.

Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагуудын тоо, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс тус салбарт оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна. Үүнтэй холбогдуулан Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон банк бус санхүүгийн байгууллагууд нь дүрмийн сангийн хэмжээг өсгөн нэмэгдүүлэх тодорхой саналуудыг Хороонд удаа дараа тавьсаар ирлээ.

Хороо банк бус санхүүгийн байгууллагуудын харилцагчдын эрх ашгийг хамгаалах, эдгээр байгууллагын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх холбогдох судалгаа, дүгнэлт гарган 2014 онд багтаан шийдвэр гаргахаар ажиллаж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хууль 2011 оны 10 дугаар сард батлагдсанаар 2012-2013 онуудад хуулийн хэрэгжилтийг хангуулах, ХЗХ-дын мөрдвөл зохих холбогдох журам, заавруудыг батлуулах ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн. Хэдий тийм боловч тус хуульд тусгагдсан зарим заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарсаар байна. Тухайлбал, тус салбарын үндэсний холбооны чиг үүрэгт тусгагдсан тогтворжилтын сангийн үйл ажиллагаа, хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд хамруулах чиглэлээр төрөөс тавих хадгаламж, хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэхэд төр болон бусад оролцогчдын чиг үүргийг тодорхой болгох, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Дээрх ажлуудыг хэрхэн хийж гүйцэтгэх талаар судалгаа хийж, санал боловсруулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх төрийн бодлогын хүрээнд Монгол улсын Засгийн газраар Зээлийн батлан даалтын сангийн давхар батлан даалтын зохицуулалтын заавар, журмуудыг яаралтай батлуулах, Сангийн үйл ажиллагааны цаашдын тогтвортой байдлыг хангах, батлан даалтанд хамрагдах жижиг, дунд үйлвэрлэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд 2014 онд Сангийн санхүүгийн тайлагналыг ил тод байлгах, нягтлан бодох бүртгэлийн системийг шинээр бүрдүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Хонконгийн Үнэт цаас, Фьючэрсийн Хороотой хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, зах зээлийн зохистой байдлыг хангах үүргийн хүрээнд хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулав. 2013.10.11.



“Үнэт цаасны төлбөр тооцооны системийн эрсдлийн удирдлага, олон улсын санхүүгийн зах зээл дэх кастодианы үйл ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурлыг зохион байгуулав. 2013.09.23-24.



Хадгаламж зээлийн хоршоодын чадавхийг сайжруулах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх төслийн хэрэгжилтийн байдалд Азийн Хөгжлийн Банкны суурин төлөөлөгч дунд хугацааны хяналтыг хийж төслийн үйл ажиллагааг хуваарийн явагдаж байна гэж үзлээ. 2013.10.24-10.26.



“Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги /2012-2016/” төлөвлөгөөний эхний жилийн хэрэгжилтийн хэлэлцүүлгийг зохицуулалтын байгууллагын Мэргэжлийн холбоод, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТХТ” ХХК-ийн төлөөлөл, Хорооны удирдлага болон ажилтнууд, Хяналтын зөвлөлийн гишүүдийг оролцуулан зохион байгуулав. 2013.04.26.



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ОЛГОСОН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ /2006-2013 он/**

Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага

№	Үйл ажиллагааны чиглэл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Хувьцаат компани	387	383	376	358	336	330	328	323
2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан ХХК	-	-	-	-	-	-	1	1
3	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага	-	-	-	-	-	-	11	12
4	Даатгалын компани	22	15	16	18	17	17	18	17
5	Хадгаламж зээлийн хоршоо	51	179	209	212	179	162	148	141
6	Банк бус санхүүгийн байгууллага	139	137	132	177	182	195	212	263

Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага

№	Үйл ажиллагааны чиглэл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	"Монголын хөрөнгийн бирж"ХК	1	1	1	1	1	1	1	1
2	"Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв"ХХК	1	1	1	1	1	1	1	1
3	Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч компани	25	36	46	48	52	92	95	91
4	Үнэт цаасны зэрэглэл тогтоох байгууллага	-	-	-	-	1	1	1	1
5	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани	-	-	-	-	-	-	8	12
6	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компани	-	-	-	-	-	-	8	14
7	Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компани	-	-	-	-	-	-	11	13
8	Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй байгууллага	-	-	13	27	27	20	31	26
9	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	-	2	6	9	9	14
10	Даатгалын зуучлагч	-	2	4	5	9	8	17	20
11	Хөдөө аж ажуйн биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага	-	-	-	-	-	-	-	34

Санхүүгийн зах зээл дээр ажиллах эрх бүхий иргэд

№	Үйл ажиллагааны чиглэл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Үнэт цаасны зах зээл дээр ажиллах мэргэжилтэн	128	132	409	315	317	930	1107	1178
2	Даатгалын төлөөлөгч	-	690	1167	1676	2061	2057	2357	3178
3	Даатгалын аудитор	-	-	29	59	69	69	76	106
4	Актуарч	-	-	9	10	12	13	15	15

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ
“САНАМЖ БИЧИГ”-ТЭЙ ГАДААД, ДОТООДЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ**

№	№	Байгууллагын нэр	Байгуулсан огноо
1.Гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд			
1	1	Санхүүгийн зохицуулах хороо, Хятадын Үнэт цаасны зохицуулах хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2008.01.24
2	2	Санхүүгийн зохицуулах хороо, Люксембургийн Засгийн газартай байгуулсан санамж бичиг	2008.10.27
3	3	Санхүүгийн зохицуулах хороо, Бүгд найрамдах Казахстан улсын Санхүүгийн зах зээл, Санхүүгийн байгууллагын зохицуулалт хяналтын агентлагтай байгуулсан санамж бичиг	2009.09.25
4	4	Санхүүгийн зохицуулах хороо, Бүгд найрамдах Солонгос улсын Санхүүгийн хяналт шалгалтын алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2010
5	5	Санхүүгийн зохицуулах хороо, Польшийн Санхүүгийн хяналт шалгалтын байгууллагатай байгуулсан санамж бичиг	2010.10.07
6	6	Санхүүгийн зохицуулах хороо, Хонконгийн үнэт цаас фьючэрсийн хороотой байгуулсан санамж бичиг	2013.10.02
2.Монгол Улсын төрийн байгууллагууд			
7	1	Санхүүгийн зохицуулах хороо, Барилга хот байгуулалтын яамны харилцан ойлголцлын санамж бичиг	2006.03.17
8	2	Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк, Сангийн яамны харилцан ойлголцлын санамж бичиг	2006.11.10
9	3	Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын даатгалын холбоо хоорондын хамтран ажиллах санамж бичиг	2009.10.30
10	4	Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2010
11	5	Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хорооны хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг	2013.11.17
12	6	Санхүүгийн зохицуулах хороо, Татварын ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2012.11.30
3.Зохицуулалтын салбарын мэргэжлийн холбоод			
13	1	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны харилцан ойлголцлын санамж бичиг	2008.03.02
14	2	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбооны харилцан ойлголцлын санамж бичиг	2008.03.02
15	3	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын харилцан ойлголцлын санамж бичиг	2009.10.22
16	4	Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын даатгагчдын холбоо хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг	2010.02.26
17	5	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын актуарчдын нийгэмлэг хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг	2010.05.05
18	6	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын харилцан ойлголцлын санамж бичиг	2012.05.21
4.Төрийн бус болон бусад байгууллагууд			
19	1	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын хамтын ажиллагааны санамж бичиг	2006.11.27
20	2	Санхүүгийн зохицуулах хороо, Малын индексжүүлсэн даатгалын төсөл хэрэгжүүлэх нэгж хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг	2007.03.01
21	3	Санхүүгийн зохицуулах хороо, Санхүү эдийн засгийн дээд сургуулийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг	2009.03.06
22	4	Санхүүгийн зохицуулах хороо, Тогтвортой амжиргаа төслийн дэргэдэх Бичил санхүүгийн хөгжлийн сантай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг	2013.01.25
5.Хэвлэл мэдээллийн байгууллага			
23	1	Санхүүгийн зохицуулах хороо, “Монголиан экономи” сэтгүүл хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг	2012.10.18

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС 2013 ОНД БАТАЛЖ
МӨРДҮҮЛСЭН ЖУРАМ, ЗААВАР, НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

Д/д	Журам, заавар, нөхцөл шаардлагын нэр	Тайлбар
Үнэт цаас		
1	1 Үнэт цаасны бүртгэлийн тухай журам	Шинээр
2	2 Хаалттай хувьцаат компанийн тухай журам	Шинээр
3	3 Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам	Шинээр
4	4 Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам	Шинээр
5	5 Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагаа эрхлэх журам	Шинээр
6	6 Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам	Шинээр
7	7 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай	Нэмэлт, өөрчлөлт
8	8 Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам	Шинээр
9	9 Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн тухай журам	Шинээр
10	10 Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн тухай журам	Шинээр
11	11 Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах тухай журам	Шинээр
12	12 Үнэт цаасны зах дээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар	Шинээр
13	13 Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулгын маягт	Шинээр
14	14 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны журам	Нэмэлт, өөрчлөлт
15	15 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам	Нэмэлт, өөрчлөлт
16	16 Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам	Шинээр
17	17 Хувь нийлүүлэгчдийн хурлын үлгэрчилсэн журам	Шинээр
18	18 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам	Шинээр
19	19 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журам	Шинээр
20	20 Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны үлгэрчилсэн журам	Шинээр
21	21 Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хорооны үлгэрчилсэн журам	Шинээр
22	22 Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны үлгэрчилсэн журам	Шинээр
Даатгал		
23	1 Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам	Нэмэлт, өөрчлөлт
24	2 Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам	Нэмэлт, өөрчлөлт
25	3 Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх, түүнд тавигдах шаардлага	Нэмэлт, өөрчлөлт
26	4 Урт хугацааны даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам	Нэмэлт, өөрчлөлт
27	5 Erdийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам	Шинээр
28	6 Erdийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам	Нэмэлт, өөрчлөлт
29	7 Erdийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам	Нэмэлт, өөрчлөлт
30	8 Erdийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага	Нэмэлт, өөрчлөлт
31	9 Erdийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах нөхцөл шаардлага	Шинээр
32	10 Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам	Шинээр

33	11	Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам	Нэмэлт, өөрчлөлт
34	12	Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам	Нэмэлт, өөрчлөлт
35	13	Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам	Нэмэлт, өөрчлөлт
36	14	Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам	Нэмэлт, өөрчлөлт
37	15	Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар	Нэмэлт, өөрчлөлт
38	16	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шинээр
39	17	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам	Нэмэлт, өөрчлөлт
40	18	Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам	Шинээр
41	19	Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага	Шинэчлэн
Бичил санхүү			
42	1	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам	Нэмэлт, өөрчлөлт
43	2	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам	Нэмэлт, өөрчлөлт
44	3	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам	Нэмэлт, өөрчлөлт
45	4	Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам	Нэмэлт, өөрчлөлт
46	5	Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар	Нэмэлт, өөрчлөлт
47	6	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар	Шинээр
48	7	Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”	Шинэчлэн
49	8	Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам	Нэмэлт, өөрчлөлт
Эрсдэлийн үнэлгээ, судалгаа санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ			
50	1	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын загвар	Шинээр
51	2	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түр журам	Шинээр
52	3	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам	Шинээр
53	4	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам	Шинээр
54	5	Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам	Шинээр
55	6	Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам	Шинээр
Компанийн засаглал			
56	1	Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны үлгэрчилсэн заавар	Шинээр
57	2	Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам	Нэмэлт өөрчлөлт